



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Хөгжим. I-V анги

Улаанбаатар
2019

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР АНГИ	10
ХОЁРДУГААР АНГИ	18
ГУРАВДУГААР АНГИ	25
ДӨРӨВДҮГЭЭР АНГИ	32
ТАВДУГААР АНГИ	39
ХАВСРАЛТ	49



БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТУШАА.1

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот


Суралцахуйн удирдамж батлах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/491 дүгээр тушаал, "Хөтөлбөр батлах тухай" А/492 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг нэгдүгээр; суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, дүрслэх урлаг, хөгжим, дизайн, технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг хоёрдугаар; бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн, технологийн сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэг, хоёр, гуравдугаар хавсралтаар батлагдсан суралцахуйн удирдамжийг нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газруудад хүргүүлж, холбогдох мэдээллийг байгууллагын цахим хаяг /mier.mn/-т байршуулахыг Боловсролын хөтөлбөрийн секторын эрхлэгч /А.Энхтогтох/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



П.ЛХАГВАСҮРЭН

ӨМНӨХ ҮГ

Суралцахуйн удирдамж, түүний зориулалт

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг суралцахуй болон багшлахуйгаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг үлгэрчлэн төлөвлөсөн баримт бичиг юм.

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөрийг жилээр болон нэгж, ээлжит хичээлээр зохистой төлөвлөх, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, хичээлийн арга зүйн санааг хөгжүүлэх, үнэлгээг үр дүнтэй зохион байгуулах хөтөч болно.

Суралцахуйн удирдамж нь арга зүйн зөвлөмж төдий бус, өнөөгийн боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл санаанд суурилсан шинэлэг арга зүйг тусгасан тул суралцахуй, багшлахуйд тулгамдаж буй бэрхшээл, сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлнэ.

Багш суралцахуйн удирдамжийг сайтар ойлгож, мөрдөн хэрэгжүүлэх нь хичээлийг үр өгөөжтэй зохион байгуулах, суралцахуйн үйл ажиллагааг бүтээлчээр дэмжих, багшлах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Суралцахуйн удирдамжийг багш нар бэлэнчлэн хуулбарлаж хэрэглэх биш, өөрсдийн туршлага, ур чадвараар баяжуулан хөгжүүлэхийн сацуу сурагчдынхаа ялгаатай байдал мэдлэг, чадвар, хандлагад тохируулан уян хатан, нээлттэйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

Суралцахуйн удирдамжийн бүтэц

Суралцахуйн удирдамж нь суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, багшид зөвлөмж, хэрэглэгдэхүүн гэсэн үндсэн бүтэцтэй.

Суралцахуйн зорилт нь сурагчийн эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн илэрхийлэл. Өөрөөр хэлбэл; тухайлсан үйл ажиллагааны үр дүнд сурагчийн эзэмших мэдлэг, чадвар юм.

Суралцахуйн үйл ажиллагаа: Багш төвтэй сургалтын арга зүйг биш, сурагчийн бүтээлч сэтгэлгээ, идэвх, оролцоо, бие даасан байдлыг хүндэтгэн дэмжсэн, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх зэрэг сурагч төвтэй сургалтын арга технологид суурилсан үйл ажиллагааг тусгасан.

Суралцахуйн зорилт бүрээр сэдэлжих, мэдлэг бүтээх сорил туршилт, дадлага ажил, даалгавар гүйцэтгэх арга, аргачлал, үр дүнгээ үнэлэх, ганцаарчлан болон багаар ажиллах арга зүйн шийдлийг зөвлөсөн болно. Мөн багш суралцахуйг дэмжих, туслах үүрэг, хариуцлагаа ухамсарлах, багийн үйл ажиллагааг хөгжүүлэх, сурсан зүйл нь хүүхэд бүрт “үр өгөөжтэй” байхад санаа тавих, хүүхэд бүрийн суралцах ялгаатай байдлыг харгалзан хичээл зохион байгуулахад анхаарах зүйлийг зөвлөмжилсөн.

Хэрэглэгдэхүүн: Энэ хэсэгт суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурах бичиг, гарын авлага, цахим болон бусад эх сурвалж, дадлага, туршилт, аялал, төсөлт хичээл, хамтын хичээлийн хэрэглэгдэхүүнийг сонгон ашиглахыг санал болгосон.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр боловсруулсан тул сургууль, багш нар судлагдахуунуудын хөндлөн ба босоо залгамж холбоог сайтар судлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Боловсролын хүрээлэн

Анги	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	I. Байгалийн дуу чимээ	II. Хэм, хэмжээ	III. Энгийн хэмнэл	IV. Аялгууны хэм, хэмнэл
1-р анги	1.1а. Байгалийн дуу чимээ, тэдгээрийн шинж төрх, өнгө аясыг сонсож тодорхойлох, ялган таних	1.2а. Хялбар дуу, аялгууг сонсож, хэмжээ хэмнэлийг тодорхойлох, жишээгээр харуулах	1.3а. Хөгжмийн төрөл зүйл (дуу, бүжиг, марш)-ийг сонсож тодорхойлох, сэтгэгдэлээ илэрхийлэх	1.4а. Хөгжмийн төрөл зүйл (дуу, бүжиг, марш)-ийг сонсож хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох
	1.1б. Дуу, дасгалыг дагаад дуулахдаа биеийн байршил, амьсгааг зөв эзэмшсэнээ харуулах	1.2б. Өөрийгөө болон бусдыг сонсож хэмжээ хэмнэлд нийцүүлэн дууны үгийг тод, зөв хуваарилж хамтран дуулах	1.3б. Сонголын тогтоолт дээр тулгуурлан 2 ба 3 хувьт хэмд хэмжээ, хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулах	1.4б. Дууны утга агуулгыг ойлгож сэтгэл хөдлөлөө илэрхийлэн, гоцлол, найрлаар хөг нийлүүлэн дуулах
	1.1в. Хөгжмийн энгийн зэмсгээр дуу авиа үүсгэх арга (цохих, сэгсрэх, шигших, хавсрах) барил эзэмшсэнээ харуулах	1.2в. Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) ялган таних, дүрсээр тэмдэглэх, хөгжмийн энгийн зэмсэг ашиглан 2 хувьт хэмд хэмнэлээр дагаж хөгжимдөх	1.3в. Хоёр ба гурван хувьт хэмд сонголын тогтоолт дээр тулгуурлан бие даан ноотоор хөгжимдөх	1.4в. Хоёр ба гурван хувьт хэмтэй дуу аялгуунд хэмнэлийн хамсраа хийж, хэмжээ, хэмнэл нийлүүлэн хамтран хөгжимдөх
	1.1г. Хөгжмийн аялгуунд нийцүүлэн найгах, ганхах, эргэх хөдөлгөөнийг гүйцэтгэх	1.2г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хүчтэй сул хувийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах	1.3г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлж, тохирох дүрийг (цэцэг, амьтад,...) хөдөлгөөнөөр илэрхийлэх	1.4г. Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах, өөрийнхөөрөө баяжуулан илэрхийлэх
	1.1д. Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж үзүүлэх	1.2д. Хоёр хувиар хэмнэл зохиосноо хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөж харуулах	1.3д. Янз бүрийн хэмнэлээр тодорхой сэдэвт зохиомж хийж (морьд, бороо, марш, бүүвэй,) үзүүлэх	
2-р анги	I. Хөгжмийн дуу авиа	II. Хөгжмийн эгшиг тэмдэглэгээ	III. Хөгжмийн эгшгийн хөдөлгөөн ба аялгуу	IV. Аялгууны шинж төрх
	2.1а. Хүний дуу хоолойн өнгө аясыг сонсож тодорхойлох, сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгддөгийг жишээгээр харуулах	2.2а. Эгшгийн өндөр намыг ялган сонсож, хөгжмийн дүрийг тодорхойлоход ашиглах	2.3а. Хялбар дуу, аялгууг сонсоод, эгшгийн өндөр нам, урт богино, аялгууны чиглэл хөдөлгөөнийг зураглах	2.4а. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох, зураглах, амьтдын төрх араншинг илэрхийлэх
	2.1б. Энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон өндрийн зураглал, тулгуур дохиог харж дуулах	2.2б. G1-C2 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулах	2.3б. F1-C1 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулахдаа үсгэн тэмдэглэгээ, зогсоцын тэмдгийг ашиглах	2.4б. C1-C2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа дууны утга агуулгыг ойлгож, өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чадахаа харуулах

2-р анги	2.1в. Өгөгдсөн аялгуунд хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа зохион хөгжимдөх	2.2в. G1-C2 эгшгүүдээр давтах, өгсөх, уруудах хөдөлгөөнийг дуулж үзүүлэх	2.3в. Цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлээр 2 хоолойгоор хөгжимдөж үзүүлэх	2.4в. Үгийн үеийг ашиглан хялбар хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимдөх
	2.1г. Хөгжмийн зохиолын айзам хэмжээг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр гүйцэтгэх	2.2г. Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн 2 хоолойгоор хөгжимдөх	2.3г. Алчуур, тууз, савх, дарцаг зэрэг хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэх	2.4г. Тодорхой сэдвээр (эрвээхий, цэцэг, шувуухай) хөгжимт хөдөлгөөн хийж, дүр төрхийг илэрхийлэх
		2.2д. Хөгжмийн зохиолын аялгууны чиглэл хөдөлгөөнийг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлэх	2.3д. Өгөгдсөн график зураглалаар (өгсөх, уруудах, давтах) аялгуу зохиох	2.4д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохируулан чөлөөт хөдөлгөөн зохиомжлох
	I. Өнгө аяс	II. Хурд, хүчдэл	III. Хөгжмийн байгууламж	IV. Хөгжмийн цараа
3-р анги	3.1а. Хөгжмийн зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган таних, зэмсгүүдийг бүлэглэн тайлбарлах	3.2а. Хөгжмийн уран бүтээлээс өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсож тодорхойлох	3.3а. Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, бүрэлдэхүүнийг (гоцлол, цөөхүүл, найрал) тодорхойлох, тайлбарлах	3.4а. Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тайлбарлах
	3.1б. Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулах	3.2б. Ноот бичлэгээс хурд, хүчний тэмдэглэгээг таньж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах	3.3б. Дууны уран бүтээл дэх давталт ялгарамжийг (бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах	3.4б. Дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг тайлбарлах, удирдаачийн дохиогоор дуулах
	3.1в. Бишгүүрээр G-H эгшгийн багтаамжид хөгжимдөх арга барил эзэмшсэнээ харуулах	3.2в. G1-D2 цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлэх	3.3в. C1-D2 цараанд ноотоор хөгжимдөх, дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлох	3.4в. C1-D2 цараанд удирдаачийн дохиогоор хөгжимдөх
	3.1г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэлийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлэх	3.2г. Хөгжмийн зохиолын агуулга, дүр, өгүүлэмжийн онцлог шинжийг хөдөлгөөнөөр дүрслэх	3.3г. Хөгжмийн зохиолын аялгууны бүтэц хэсгийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлэх	3.4г. Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэлтэй гүйцэтгэх
	3.1д. Хөгжмийн зэмсгүүдийн дуу авиа үүсгэх арга замыг тодруулж ангилах	3.2д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг зураглалаар илэрхийлэх	3.3д. Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлэх (A1, A2, A3)	3.4д. Өгөгдсөн хэмд хэмнэлийн янз бүрийн багцлал зохиох

	I. Сэтгэл хөдлөл ба хөгжим	II. Уран илэрхийллийн аргууд	III. Хөгжмийн энгийн хэлбэрүүд	IV. Хөгжмийн зохиолын дүр дүрслэл
4-р анги	4.1а. Хөгжмийн зохиолын лад хөгийг (мажор, минор) ялган сонсох, агуулга дүрийг тайлбарлах	4.2а. Хөгжмийн зохиолоос уран илэрхийллийн хэрэглүүрийг сонсож таних, тодорхойлох	4.3а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг ялган таних (AB, ABA)	4.4а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг агуулгатай холбон тайлбарлах
	4.1б. Мажор, минорын ладад хялбар аялгууг ноотоор дуулах	4.2б. Сонгогдсон бүтээлийг уран илэрхийлэлтэй дуулах	4.3б. Хүүхдийн болон ардын дууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр дуулах	4.4б. Ноот бичлэгт ажиглалт хийж, дууны утга агуулгыг илэрхийлэн хоёр хоолойгоор дуулах
	4.1в. Мажор, минорын ладад хялбар аялгууг бишгүүрээр (пианика) хөгжимдөх	4.2в. Хялбар дуу аялгууг уран илэрхийлэлтэй хөгжимдөх	4.3в. Хялбар дуу аялгууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр хөгжимдөх	4.4в. Хялбар дуу, аялгууны айзам хэмжээ, чиглэл хөдөлгөөнийг тодорхойлж, хоёр хоолойгоор хөгжимдөх
	4.1г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний өнгө аясыг мэдэрч, сэтгэл хөдлөлөө илэрхийлж бүжиглэх	4.2г. Хөгжмийн зохиолын уран илэрхийллийн хэрэглүүрийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлэх	4.3г. Тодорхой сэдэв, дүрийг илэрхийлэх хөгжмийн зохиолын сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлох	4.4г. Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг график дүрслэл, зурах, бичих, жүжигчилэх зэргээр илэрхийлэх
	4.1д. Сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэл (баярлах, гуниглах, бодлогошрох)-д тохирох хөгжмийн сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлох		4.3д. Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг ашиглан сэтгэл хөдлөлийг илэрхийлэх, тодорхой дүрслэл үүсгэх	
5-р анги	I. Аялгуу	II. Хөг эгшиглэгээ	III. Хэлбэр	IV. Хөгжмийн хэл
	5.1а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг (AB, ABA, ABC, A1, A2, A3) тодорхойлох, ялган таних	5.2а. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг (пентатоник, диатоник) сонсож тодорхойлох	5.3а. Эгшиг зохирлыг (консонанс, диссонанс, интервал) сонсож таних	5.4а. Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг (дуулаач, дан хөгжим) сонсож тодорхойлох
	5.1б. Диатоник, пентатоник мажор, минорын ладад дуулж ялгааг тайлбарлах	5.2б. Эгшиг зохирлоор (консонанс, диссонанс интервал) дуулж онцлогийг тайлбарлах	5.3б. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулж, хөгжимдөх	5.4б. Удирдаачийн дохиогоор хурд хүчний өөрчлөлтийг илэрхийлж гоцлол, найрал хэлбэрээр дуулах, хөгжимдөх
	5.1в. Утга санаа илэрхийлж уран яруу (нюанстай) гоцлол болон найрал хэлбэрээр хоёр хоолойгоор хөгжимдөх	5.2в. Бүжгийн энгийн элемент бүхий дасгалыг гүйцэтгэх	5.3в. Хөгжмийн зохиолын агуулга дүрийг хөдөлгөөнөөр илэрхийлэх	5.4в. Хөгжим болон хөдөлгөөний уялдаа холбоог тайлбарлах
	5.1г. Тодорхой сэдвийн (галт тэрэг, уралдаан, бүүвэй гэх мэт) дагуу хэмнэлийн зохиомж хийх	5.2г. Хөгжмийн энгийн зэмсгүүдийг ашиглан цохивор хөгжмийн найруулгыг жишээгээр харуулах	5.3г. Өгөгдсөн аялгууг хөгжүүлэх, хувилбарлах	5.4г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг янз бүрийн арга хэлбэрээр (өнгө будаг, зураглал) илэрхийлэх

Үнэлгээ:

Бага боловсролын түвшинд үнэлгээний блүпринтыг дараах байдлаар хийнэ.

Даалгаврын бүтэц	Үнэлгээний зорилт	Даалгаврын агуулга	Даалгавар			
			тоо	оноо	хугацаа (минут)	төрөл
Хэсэг А	Мэдлэг, ойлголт	Хөтөлбөрийн агуулга Сурах бичгийн	1	2	10	Сонгох, богино хариултат
Хэсэг Б	Мэдлэгээ хэрэглэх	даалгаврыг хөгжүүлэн баяжуулсан агуулга	2	4	30	Бүтээх хариултат
Нийт			3	13	40	

Жишээ IV анги:


Хэсэг А.

Даалгавар 1

[2]

- а. Дэвсгэр шугам дээрх эгшгүүдийг нэрлэж бичнэ үү. Нэрлэсэн ноотныхоо уртыг тэмдэглэж бичээрэй. [1]





в. Яагаад сонгосноо тайлбарлаж бичнэ үү.

[1]

НЭГДҮГЭЭР АНГИ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Байгалийн дуу чимээ		
1.1а. Байгалийн дуу чимээ, тэдгээрийн шинж төрх, өнгө аясыг сонсож тодорхойлох, ялган таних	- Байгалийн дуу чимээ, амьтдын дуу хоолойг сонсож таниад дуурайна. Жишээ нь: мэлхий, хөхөө, нохой, таван хошуу мал, бороо, салхи, шуурга... - Тэдгээрийг хооронд нь харьцуулж өнгө аяс, чанга, сул хүчийг тодорхойлно. - Сонссон дуу чимээ, байгалийн үзэгдлийг жүжигчилсэн тоглолтоор үзүүлнэ. Жишээ нь: “Хөгжилтэй аялал” - Жижиг бөмбөр, кастаньет, шагшуур зэрэг хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтыг бичлэгээс сонсоод, тодорхойлно. - Ямар, ямар хөгжмийн зэмсэг болохыг таамаглаж ярилцана. - Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын шинж төрхийг бүдүүн, нарийн, чанга, сул... гэх мэтээр тодорхойлно. - Байгалийн дуу чимээ, амьтдын дуугаралт, хөдөлгөөний онцлогийг хөгжмийн эгшгээр төсөөлж ярилцана. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйлээр хүрээлэн байгаа орчны тухай хүүхдийн төсөөллийг баяжуулах, өнгө аясыг тодорхойлох, аялгууны шинж төрх, уран илэрхийллийн арга, зохиолын бүтэц, төрөл зүйлтэй танилцуулах боломжийг бүрдүүлэх, төрсөн сэтгэгдлээ ярих, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх эрмэлзлийг байнга урамшуулж дэмжээрэй.	Сонсох хөгжим: Байгалийн дуу чимээтэй бичлэг. Үүнд: - Байгалийн дуу чимээ (CD-1) https://www.youtube.com/watch?v=wKnS8VPxpHI - Амьтдын дуу чимээ (CD-2, 3) https://www.youtube.com/watch?v=c5EJlvjK0iQ - Цаг агаарын үзэгдэл (CD-4) https://www.youtube.com/watch?v=VT_PDr8tp3U https://www.youtube.com/watch?v=PazmXWSOchw Дуулах дуу: Хөг. С.Батболд “Хувиршгүй тоолол” Техник, бусад хэрэглэгдэхүүн: - Хөгжмийн энгийн зэмсгүүд (Жижиг бөмбөр, Цан, Шагшуур, Шигшүүр, Савх, Гурвалжин) - Магнитофон

1.1б. Дуу, дасгалыг дагаад дуулахдаа биеийн байршил, амьсгааг зөв эзэмшсэнээ харуулах	- Дуулахын өмнө биеэ хэрхэн бэлтгэхийг (зөв суух, зөв зогсох) биечлэн харуулна. - Дуулах үеийн биеийн байршил болон дуу хоолойн дуугаралтын үүргийг ярилцана. - Дуулахдаа амьсгааг хэвлийгээр авах, мөрөө өргөхгүй байх, цэх шулуун зогсож, фразыг харгалзан амьсгааг хуваарилана. - Хялбар дуу, аялгууны чиглэл хөдөлгөөнийг гараар дүрслэн дуулна. Багшийн анхаарах зүйл: Бага ангид дуулах үйл нь зөв дуулах аргад сурах, хөгжмийн утга агуулгыг ойлгож, зөв илэрхийлэхэд чиглэнэ. Үүнд: дуу авианы зохион байгуулалт, хэллэг, амьсгаа, хүч, өнгө цэвэршүүлэх, дуу хоолойн багтаамжийг өргөтгөх, хөгжмийн сонсголыг хөгжүүлэх зэрэг болно. Ийм учраас ярианы өндөрлөг, дуу авианы өндөрлөгийн ялгааг ойлгуулж, дан (унисон) хоолойн дуулалтыг эзэмшүүлнэ.	Дуулах дуу: - Б.Цэвээнсүрэн “Яагаад” - Л.Галмандах “Шүдээ хайрлая” - С.Батболд “Дэлхийгээ би мэднэ” - С.Батболд “Би дуучин”
1.1в. Хөгжмийн энгийн зэмсгээр дуу авиа үүсгэх арга (цохих, сэгсрэх, шигших, хавсрах) барил эзэмшсэнээ харуулах	- Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтыг сонсоод ялгаж, танина. Жишээ нь: морин хуур, шагшуур, кастаньет, төгөлдөр хуур, бөмбөр, хуучир гэх мэт хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтыг бичлэгээс сонсоод, таньсан дарааллаар дугаарлана. - Ямар хөгжмийн зэмсэг болохыг сонсож таниад ярилцана. - Хөгжмийн энгийн зэмсгүүд болон өөр төрлийн зургуудыг ангилаад бүлэглэнэ. - Д.Кабалевский “Бүрээч, бөмбөрч” зохиолыг сонсож хэмнэлээр хамтран хөгжимдөнө. - Энгийн хөгжмийн зэмсгийн дуугаралтын шинж төрхийг тодорхойлно. Жишээ нь: Зүүд эсвэл мөрөөдөл сэдэвт зураг дээр ярилцаад тохирох энгийн зэмсгийг сонгож, өнгө аясыг тодорхойлно. - Тухайн хөгжмийн зэмсгээр ямар дүрслэл үүсгэж болох, аялгууны аль хэсэгт илүү тохиромжтой болох талаар ярилцана. - Энгийн хэмнэл (хагас ноот, бүтэн ноот, 2 хувьт хэм, тэдгээрийн зогсоц)-ийг сонсож мэдрэх, тэдгээрийг тэмдэглээд уншина. - Эгшгийн хөдөлгөөн, хэмнэл, хурд, хүчийг хөгжмийн зохиолоос сонсож тодорхойлно. - Дуу, дан хөгжмийн аязыг сонсож хурд, хүч, хэмнэлийг утга агуулгатай холбон ойлгоно. Багшийн анхаарах зүйл: Хамгийн гол нь сурагчид багшийн тоглолтыг сонсоод дагах биш, харин өөрсдөө зураглал хараад тоглох нь чухал гэдгийг анхаараарай. Үүний тулд сурагчдад дүрсээ сайтар ажиглаад уншина, уншихдаа хэмжээгээ алдахгүйн тулд тоолж хөгжимдөнө гэсэн ойлголтыг сайн өгөх хэрэгтэй.	Сонсох хөгжим: - Д.Кабалевский “Бүрээч, бөмбөрч” https://www.youtube.com/watch?v=mDzka9AgHfY - С.Батболд “Хичээлийн завсарлагааны дуут бүжиг” Техник хэрэгсэл: - Даралтат хөгжим

1.1г. Хөгжмийн аялгуунд нийцүүлэн найгах, ганхах, эргэх хөдөлгөөнийг гүйцэтгэх	- Хөгжмийн зохиолыг сонсоод аялгууны шинж төрхөд тохируулан хөдөлгөөн хийнэ. - Аялгууны шинж төрхийг сэтгэл хөдлөлөөр илэрхийлнэ. - Бусадтайгаа хамтран дүр бүтээж тоглох, бие даан хийж гүйцэтгэнэ. - Дуут бүжгийн хөдөлгөөнийг хамт олноороо болон бие даан гүйцэтгэнэ. - Хөгжмийн аянд тохируулан навчсын салхинд хийсэх эргэлдэх, унах хөдөлгөөнийг хийнэ. Багшийн анхаарах зүйл: Өндөрлөгийн сонсгол, хэмнэлийн мэдрэмж нь мэдрэлийн булчингуудын үйл ажиллагаатай олон талаар холбоотой хөгждөг. Иймээс хүүхдийг хөгжүүлэх тулгуур дохионы арга, хөдөлгөөнд тулгуурласан гарын дасгал, хөгжимт хөдөлгөөнийг түлхүү ашиглахаар оруулж өгсөн.	Хөгжимт хөдөлгөөн: - “Навчис” /CD-5/ https://www.youtube.com/watch?v=CyJlfdA71Lc - “Шувуухай” https://www.youtube.com/watch?v=VZR38RD-qY https://www.youtube.com/watch?v=WTcyXJ2m2_g - “Далай” /CD-6/ https://www.youtube.com/watch?v=3qoEVOF1D8M
1.1д. Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж үзүүлэх	- Гарын доорхи материалаар дуу дарам, шагшуур зэрэг хөгжмийн энгийн зэмсэг өөрсдөө хийж, дуу авиа үүсгэж үзүүлнэ. - Хийсэн хөгжмийн зэмсгээрээ байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж, дүрд хувирч тоглоно. - Өгөгдсөн энгийн хэмнэлийг өөрийнхөөрөө баяжуулан тоглоно. - Тухайн хөгжмийн зэмсгийн онцлогийг гаргаж, дуу авиа үүсгэнэ. - Ойн чуулга, амьтдын хүрээлэн, зөгийн нисэлтийн дуу авиагаар зохиомж хийнэ. - Морьд, бороо, марш, бүүвэй сэдвээр хэмнэлийн зохиомж хийнэ. Багшийн анхаарах зүйл: Дуу чимээг сонсоод зөв дуугаргах, сэтгэлийн хөдөлгөөнөө гаргаж тоглоход анхаарах хэрэгтэй. Хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтыг ялгахад нэршилгээг анхаарч ажиллана. Хэрэглэгдэхүүнтэй зөв, аюулгүй харьцаж ажиллахад анхаарах хэрэгтэй болно.	Ашиглах материал: Шүр, сувд, хайч, хөөсөнцөр, скок, гуурс, цэвэр усны сав, өнгийн цаас, тууз, жигнэмэгийн хайрцаг /CD-9/ https://www.youtube.com/watch?v=7sUNXA4NYKI
2. Хэм, хэмжээ		
1.2а. Хялбар дуу, аялгууг сонсож хэмжээ хэмнэлийг тодорхойлох, жишээгээр харуулах	- Хялбар дуу, аялгууг сонсоод хэмжээ, хэмнэлийг тодорхойлно. - Тодорхойлсон хэмжээ, хэмнэл дээрээ дуу, аялгууны жишээ гаргаж тайлбарлах - Хэмнэлийг тоглоод харьцуулж ярилцана. - Ангид байгаа хөгжмийн энгийн зэмсгээр тоглож, тэдгээрийн дуугаралт, хэмжээ, хэмнэлийг харьцуулна. - Өөрийн мэдэх дууны жишээн дээр хэмжээ, хэмнэлийг тодорхойлно.	Сонсох хөгжим: -Л.В.Бетховен “Элизе” https://www.youtube.com/watch?v=kWctpFGHThs -С.Гончигсумла “Марш” -С.Рахманинов “Полька” -Ц.Эрдэнэ “Бүүвэйн дуу - “Амьтдын марш https://www.youtube.com/watch?v=YXtYahyTHfU https://www.youtube.com/watch?v=IAIGb1IfpBw - И.Штраус “Вальс” https://www.youtube.com/watch?v=YyyX4CThY38&t=8s

	Багшийн анхаарах зүйл: Хүүхэд хөгжим сонсоод сэтгэлдээ хийсвэрлэж, дүрслэл үүсгэн ургуулан бодож, сэтгэл хөдлөлийн үүднээс баярлах, гуниглах, эргэцүүлэх зэрэг сэтгэлийн хөдөлгөөнд ордог. Иймээс хөгжмийг сонсгохдоо уран зохиол, яруу найраг, уран зургийг ашиглан сэдэв хоорондын уялдаагаар агуулгын хувьд холбож өгөх нь сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хөгжүүлэхэд үр дүнтэй арга болно.	
1.26. Өөрийгөө болон бусдыг сонсож хэмжээ хэмнэлд нийцүүлэн дууны үгийг тод, зөв хуваарилж хамтран дуулах	- Эгшгийн чанга сул, өндөр нам, аялгууны хурдыг мэдэрч дуулна. - Аялгууны шинж төрх, агуулга дүр дүрслэлийг илэрхийлэн хэмжээ, хэмнэлийг дуулна. - Хоолойн болон амьсгалын дасгалыг хэд хэдэн хувилбараар гүйцэтгэнэ. - Өөрийгөө болон бусдыг сонсож, хамтаараа хөгжимтэй, хөгжимгүй дуулна. - Үндсэн 7 эгшгийг шатлалын аргаар тэмдэглэх, унших, дуулах дадлага хийнэ. - Ноотны зогсоцыг ойлгож, тэмдэглэгээг уншиж сурах дасгал, даалгаврыг гүйцэтгэнэ. - Зогсоцтой дуу, дасгал дуулах дадлага хийнэ. - Гарын хөдөлгөөнөөр энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон үзүүлж дуулна. - Эгшгийн дарааллыг өгсөх уруудах чиглэлд янз бүрийн хэмнэлээр дуулна. - Сонсголын тогтоолт дээр тулгуурлан дуулна. - Дүрс, зураглалаар өгөгдсөн хэмнэлийн хүчийг ярилцаад тайлбарлана. Жишээ нь: дуулж, хөгжимдөхдөө багшийн гарын дохилтыг анхаарч зэрэг эхэлж, дуусгах Багшийн анхаарах зүйл: Дан хоолойн дуулалтын явцад дуулах техник эзэмшүүлэх ажиллагаа явагдана. Дууны уран бүтээл дээр ажиллахдаа дууг сонсгож, хүндрэлтэй хэсгийн тайлбар, мэдээлэл хийсний дараа заах үйл ажиллагаанд орно. Заахдаа сурагчдын хараа, сонсгол, хөдөлгөөний сэрлүүдийг нэгтгэсэн үйлийг хийх ба багшийн гарын дохио нь өндөрлөг, хэмнэл, хэллэг, амьсгаа, дуулахуйн ур дүйг мэдрүүлэхэд чиглэнэ. Дууны уран бүтээлийг хүүхдийн боломж, онцлогт тохируулан сонгоогүйгээс үг хэллэг, аялгуу, хэмнэл, хурд, диапазон, регистр, амьсгааны зэрэг хүндрэл, бэрхшээл тулгарч болохыг санаарай.	Дуулах дуу: - М.Булган “Эрдмийн үсэг сурлаа” - С.Батболд “Бага ангийн багшдаа баярлалаа” - Б.Бямбабаяр “Дүүдээ хэлж өгнө дөө” Ном, сурах бичиг: - Хөгжим I сурах бичиг - Хөгжим I- Багшийн ном
1.2в. Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) ялган таних, дүрсээр тэмдэглэх, хөгжмийн энгийн зэмсэг ашиглан 2 хувьт хэмд хэмнэлээр дагаж хөгжимдөх	- Багшийн гарын дохиог ойлгож хөгжимдөнө. Жишээ нь: сурагчид янз бүрийн хэмжээтэй хэмнэлийн дасгалыг зэрэг эхэлж, төгсгөх (салаа салаагаар энгийн зэмсгийг хуваарилана). - Сонсголын тогтоолт дээр тулгуурлан янз бүрийн хэмжээгээр хэмнэлийн дасгалыг багшийн дохиогоор хөгжимдөнө. - Дууны утга агуулга, дүр дүрслэлийг сэтгэл хөдлөлөө илэрхийлэн хэмнэлээр хөгжимдөнө. - Сурсан дуу, сонссон хөгжмийн хэмнэлээ ганцаараа болон анги нийтээрээ хөгжимдөнө.	Дуулах дуу: - Шүдээ хайрлая - Хулгана Үзүүлэн, материал: - Хэмнэлийг харуулсан үзүүлэн - Ноотны дэвтэр, харандаа

	- Хэмнэлийн янз бүрийн зураглалуудыг бие даан болон бусадтай хамтран хөгжимдөнө. - Хялбар ноот бичлэгийг унших, хэмнэлээр хөгжимдөнө. - Дуу, дан хөгжмийн аязыг сонсоод, хүчтэй сул хувийг ялган хэмнэлийн хамсраа хийнэ. Багшийн анхаарах зүйл: <i>Хөгжим тоглохын өмнө багш заавал тоолж хэмжээ өгнө. Ингээгүйгээс сурагчид өөр өөрсдийн хэмжээгээр эхэлж улмаар ангид замбараагүй байдал үүссэнээр сурагчдын анхаарал сарнидаг. Багш нар ноотны задаргааг алим хуваах, шугам ашиглах, хүснэгтээр ажиллах гэх мэт тоглоомын аргаар, сонирхолтойгоор ойлгуулах хэрэгтэй.</i>	
1.2г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хүчтэй сул хувийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах	- Хөгжимдөхдөө сэтгэл хөдлөл, хүчдэлийг (чанга сул) илэрхийлж тоглоно. - Өөрсдийн танил тодорхой өндөрлөггүй хөгжмийн зэмсгийг дуугаралтаар нь таньж, сонгон хөгжимдөнө. - Хүрээлэн байгаа орчны дуу чимээ, дуугаралтын шинж чанар (урт богино, өндөр нам, чанга сул)-ыг харьцуулан жишиж хөгжимдөнө. - Хөгжмийн хялбар аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд, хүчийг илэрхийлж хэмнэлээр хөгжимдөнө. - Зохиолын утга санаатай холбоотой өөрсдийн төсөөллөө хэмнэлээр илэрхийлнэ. - Сонсож буй аялгууны хэмнэлд тохируулан хөгжимдөнө. - Тодорхой өндөрлөггүй энгийн зэмсгээр аялгууг дагаж хэмнэлээр хөгжимдөнө. - Аялгууны шинж төрх, хэмнэлийн хүчтэй, сул хувийг мэдэрч бүжиглэнэ. - Аялгууны өгсөх, уруудах, өнгө давтах, үсрэлттэй хөдөлгөөнийг мэдэрч биеийн хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Багшийн анхаарах зүйл: <i>Хөгжимт хөдөлгөөн, тоглоомыг тэдний сонирхож, мэдэхийг хүсч байгаа болон тэдний эргэн тойронд гарч буй дуу чимээ, дүрслэлээс сэдэвлэж хийх нь тохиромжтой байдаг. Хөгжимт хөдөлгөөн хийх, тоглох зэрэг нь хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх, биеийн том, жижиг булчингийн хөгжлийг хангах, хүүхдийн бие даасан байдал, өөрийгөө илэрхийлэх чадвар, бүтээлч сэтгэлгээг практик үйл ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэхэд чухал алхам болно.</i>	Хөгжимт хөдөлгөөн: - Шувуухай /CD-15/ https://www.youtube.com/watch?v=sgjLCbXyhdU - Хүүхэлдэй /CD-24/ https://www.youtube.com/watch?v=aFFVPIIxZlw - Бөмбөрчин /CD-25/ https://www.youtube.com/watch?v=oiJ5YL9AHbc Дуулах дуу: - Ш.Чинзориг “Хонхот хүүхэлдэй” - С.Батболд “Наадацгаая” Техник хэрэгсэл: - CD, DVD сонсох хөгжим
1.2д. Хоёр хувиар хэмнэл зохиосноо хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөх	- Хүрээлэн байгаа орчны дуу чимээ, дуугаралтын шинж чанар (урт богино, өндөр нам, чанга сул)-ыг харьцуулан жишиж 2 хувиар хэмнэл зохион хөгжимдөнө. - Хөгжмийн хялбар аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд, хүчийг илэрхийлж хэмнэлээр хөгжимдөнө. - Зохиолын утга санаатай холбоотой өөрсдийн төсөөллөө хэмнэлээр илэрхийлнэ. - Өгөгдсөн хэмжээнд тохирох хэмнэл зохиож, түүгээр дүр бүтээж тоглоно.	

3. Энгийн хэмнэл		
1.3а. Хөгжмийн төрөл зүйл (дуу, бүжиг, марш)-ийг сонсож тодорхойлох, сэтгэгдэлээ илэрхийлэх	- Дуу, бүжиг, маршийг сонсоод ялгаж танина. - Дуу, бүжиг, маршийн шинж төрхийг сонсоод хэмнэлийг мэдрэн тайлбарлана. - Хөгжмийн зэмсгийн дуугаралтыг хэрхэн таньж мэдсэн талаар ярилцаж таамаглалаа батлана. - Оросын суут хөгжмийн зохиолч П.И.Чайковский “Шелкунчик” бүжгийн жүжгийн вальс, Ж.Фужикийн марш, Уолт Диснейн хүүхэлдэйн киноны амьтдын марш, Гена матар хүүхэлдэйн киноны Чебурашкагийн дууг сонсож, аялгууны шинж төрхийг тодорхойлно. Багшийн анхаарах зүйл: Сурагчдаар аялгууны шинж төрхийг тодорхойлуулах явцад зохиолын аялгуу, хэмнэлийг анхааралтай сонсоход анхаарна. Үүнд: - Хөгжилтэй цовоо сэргэлэн, уйтгартай, намуун зөөлөн, хурдан удаан гэх мэт тэмдэг нэрээр аялгууны шинж төрхийг тодорхойлно. Аялгууны шинж төрхийг тодорхойлсны дараа түүнд тохирох хэмнэлийн хамсрааг гүйцэтгүүлэх ба сонсголын ажиглалтаар хэмнэлийн зураглалыг багшийн тусламжтайгаар олж тогтооход чиглүүлэх хэрэгтэй.	Дуулах дуу: - Л.Галмандах “Арав гэж юу вэ?” - С.Батболд “Би жагсаж чадна”, “Дэлхийгээ би мэднэ”
1.3б. Сонсголын тогтоолт дээр тулгуурлан 2 ба 3 хувьт хэмд хэмжээ хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулах	- Аялгууны шинж төрх, агуулга, дүр дүрслэлийг илэрхийлэн 2 ба 3 хувьт хэмд хэмжээ, хэмнэлийг зөв дуулна. - 2 ба 3 хувьт хэмд хэмжээ хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулж харуулна. - Хоолойн дасгал, амьсгалын дасгалыг хэд хэдэн хувилбараар гүйцэтгэнэ. - Ганцаараа болон хамтаараа хөгжимтэй, хөгжимгүй дуулна. Багшийн анхаарах зүйл: Дан хоолойн дуулалтыг эзэмшүүлэх явцдаа дуулах техник эзэмшүүлэх ажиллагааг хослуулна. Дууны уран бүтээл дээр ажиллахдаа дууг сонсгож, хүндрэлтэй хэсгийн тайлбар, мэдээлэл хийсний дараа заах үйл ажиллагаанд орно. Заахдаа сурагчдын хараа, сонсгол, хөдөлгөөний сэрлүүдийг нэгтгэсэн үйлийг хийх ба багшийн гарын дохио нь өндөрлөг, хэмнэл, хэллэг, амьсгаа, дуулахуйн ур дүйг мэдрүүлэхэд чиглэнэ.	Дуулах дуу: Б.Цэвээнсүрэн - “Яргуй дэлгэрлээ” Л.Галмандах - “Шүдээ хайрлая”
1.3в. Хоёр ба гурван хувьт хэмд ноотоор болон сонсголын тогтоолт дээр тулгуурлан бие даан хөгжимдөх	- 2 ба 3 хувьт хэмнэлд тохируулан алга таших, энгийн хөгжмийн зэмсгээр хөгжимдөнө. - 2 ба 3 хувьт хэмд хэмнэл зохион хөгжмийн энгийн зэмсгийг ашиглан янз бүрийн дараалалд оруулж хөгжимдөнө. - Аялгуу сонсонгоо зургийг ажиглаад, шинж төрхийг ярилцах, зурагт тохирох хэмнэл зохион хөгжимдөж гүйцэтгэнэ. - Сонсголын тогтоолт дээр тулгуурлан бие даан хөгжимдөж гүйцэтгэнэ.	Үзүүлэн, материал: - Хөгжмийн энгийн зэмсэг болох бөмбөр, шагшуур - Зурагт үзүүлэн

	Багшийн анхаарах зүйл: <i>Сурагчдын анхаарлын төвлөрөлт, сонсох идэвхи өрнөхөд уран бүтээлийн тухай багшийн яриа чухал нөлөөтэй. Уран бүтээлийн тухай багшийн яриа амьд дүр төрхтэй байхаас гадна зурагт болон загвар үзүүлэн, кино дүрс бичлэгийг ашиглах, гол сэдвийг дуулах, хэмнэлийн хамсраа хийх ажиллагаатай нэгтгэх хэрэгтэй.</i>	
1.3г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлж, тохирох дүрийг (цэцэг, амьтад,...) хөдөлгөөнөөр илэрхийлэх	- “Шувуухай” хөгжимт хөдөлгөөний аялгууны шинж төрх, хэмнэлийн хүчтэй, сул хувийг мэдэрч бүжиглэнэ. - Аялгууны өгсөх, уруудах, өнгө давтах, үсрэлттэй хөдөлгөөнийг мэдэрч биеийн хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Жишээ нь: Далай, Шувуухай зэрэг хөгжимт хөдөлгөөн - Хөгжмийн зохиолыг сонсоод аялгууны шинж төрхөд тохируулан хөдөлгөөн хийнэ. - Аялгууны шинж төрхийг сэтгэл хөдлөлөөр илэрхийлж гаргана. - Бусадтайгаа хамтран дүр бүтээж тоглох, бие даан хийж гүйцэтгэнэ. Багшийн анхаарах зүйл: <i>Хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх зорилгоор хөгжимт хөдөлгөөн бүхий хэмнэлийн олон хувилбарт дасгалыг оруулж, энгийн дасгалаас аажмаар хүндрүүлж ажиллах хэрэгтэй.</i>	Хөгжимт хөдөлгөөн: - “Навчисын бүжиг” https://www.youtube.com/watch?v=BDajveWXXXM https://www.youtube.com/watch?v=CyJlfdA71Lc - “Шувуухай” https://www.youtube.com/watch?v=WTcyXJ2m2_g - “Далай” видео бичлэг https://www.youtube.com/watch?v=zIKJyHVeQwo
1.3д. Янз бүрийн хэмнэлээр тодорхой сэдэвт зохиомж хийж (морьд, бороо, марш, бүүвэй,) үзүүлэх	- Морьд, бороо, марш, бүүвэй сэдвээр хэмнэлийн зохиомж хийнэ. - 3 хувьт хэмнэлээр вальс бүжгийн дасгал, товшилтыг хийж гүйцэтгэнэ. - Өгсөх, уруудах чиглэлийн эгшгийн цувааг сонсоод, хөдөлгөөнөөр илэрхийлнэ. - Янз бүрийн хэмнэлээр өгөгдсөн дасгалыг өөрийнхөөрөө баяжуулан тоглоно. - Өндөр нам, урт богино, чанга сул, хурдан удаан, хүнд бараан, гэрэлтэй, хөнгөн цоглог үгийн тусламжтайгаар янз бүрийн дүр бүтээнэ. - Хэмнэлийн бодлого, өгөгдлийг гүйцээж бодно. Багшийн анхаарах зүйл: <i>Хөгжим сонсох үйлээр хүрээлэн байгаа орчны тухай хүүхдийн төсөөллийг баяжуулах, өнгө аясыг тодорхойлох, аялгууны шинж төрх, уран илэрхийллийн арга, зохиолын бүтэц, төрөл зүйлтэй танилцуулах боломжийг бүрдүүлэх, төрсөн сэтгэгдлээ ярих, сэтгэл хөдлөлөө зохиомжлон илэрхийлэх эрмэлзлийг байнга урамшуулж дэмжээрэй.</i>	Үзүүлэн, материал: - Зохиомжид тохирох ая
4. Аялгууны хэм, хэмнэл		
1.4а. Хөгжмийн төрөл зүйл (дуу, бүжиг, марш)-ийг сонсож хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох	- Дуу, бүжиг, маршийг сонсоод хэмнэлийг ялгаж танина. - Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/ ийг сонсож хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлно. - Зураг ажиглан сонссон хөгжмийн дүрслэлд тохирохыг сонгон аялгууны шинж төрх, хэмнэлийг тодорхойлно.	Сонсох хөгжим: Д.Кабалевский “Бүрээч бөмбөрч” М.И.Глинка “Вальс” https://www.youtube.com/watch?v=vvTNDj1C2AY - “Амьтдын марш” - “Үлгэрийн баатрууд”

	- Дуу дуулахдаа хэмнэлийг тодорхойлно. Жишээ нь: “Дэлхийгээ би мэднэ”, “Би дуучин” дууны хэмнэлд тохирох хөдөлгөөн зохиох, хэмнэлтэй хамсран гүйцэтгэх - Хөгжмийн төрөл зүйл (дуу, бүжиг, марш)-ийг сонсоод хэмнэл, аялгууны шинж төрхийг харьцуулж ярилцах Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаа нь хөгжмийн сургалтын хамгийн чухал хэсэг бөгөөд хүүхдийн сэтгэл хөдлөл, анхаарлыг хөгжүүлэх чухал арга болдог. Хөгжим сонсож утга агуулга, хөгжмийн дүрийг хүртэхэд сонсголын ажиглалт чухал үүрэгтэй тул хөгжим сонсох идэвх сонирхолыг өрнүүлэх, хэрхэн сонсох зөвлөгөөг тогтмол өгч байх хэрэгтэй.	https://www.youtube.com/watch?v=2ChrRWq7fmQ - CD, DVD сонсох хөгжим Үзүүлэн, материал: - Зурагт үзүүдэн - Даралтат хөгжим
1.4б. Дууны утга агуулгыг ойлгож сэтгэл хөдлөлөө илэрхийлэн, гоцлол, найрлаар хөг нийлүүлэн дуулах	- Эгшгийн чанга сул, өндөр нам, аялгууны хурдыг мэдэрч дуулна. - Аялгууны шинж төрх, агуулга, дүр дүрслэлийг илэрхийлэн хэмжээ, хэмнэлийг зөв мэдэрч дуулна. - Хоолойн дасгал, амьсгалын дасгалыг хэд, хэдэн хувилбараар гүйцэтгэнэ. - Дууны утга агуулгыг ойлгож сэтгэл хөдлөлөө илэрхийлэн ганцаараа болон хамтаараа хөгжимтэй, хөгжимгүй дуулна. Багшийн анхаарах зүйл: Хэл яриагаар дамжуулан хэмнэлийн сонсголыг хөгжүүлэх боломжтой. Жишээ нь: хурц тод хэллэг, өгүүлэн ярих, нэрлэх, тоолох, тоочих, яриан дунд амьсгаа авах, түр зогсох нь бүгд тодорхой хэмнэлтэй. Иймээс дууны үг, шүлэг, яруу найраг, өгүүллэг, ардын аман зохиолоос үлгэр, хэлц үг, зүйр үг, түргэн хэллэг, оньсого тааврыг утга илэрхийлж зөв уншуулах нь хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх, дикц (тод хэллэг) сайжруулах, амьсгааны багтаамж тэлэх, хэллэг зүгшрүүлэх чухал арга хэрэглүүр болно.	Дуулах дуу: - М.Булган “Эрдмийн үсэг сурлаа” - С.Батболд “Бага ангийн багшдаа баярлалаа” - С.Мааяа “Сайн уу муу юу аль нь вэ хө”
1.4в. Хоёр ба гурван хувьт хэмтэй дуу, аялгуунд хэмнэлийн хамсраа хийж, хэмжээ, хэмнэл нийлүүлэн хамтран хөгжимдөх	- Сонсож буй аялгууны хэмнэлд тохируулан алга таших ба түүнийгээ хосоор болон хамтаар хөгжимдөнө. - Тодорхой өндөрлөггүй энгийн зэмсгээр аялгууг дагаж хэмнэлээр хөгжимдөнө. - Энгийн хөгжмийн зэмсгээр 2 ба 3 хувьт хэмнэлийг ноотоор хөгжимдөнө. - Өгөгдсөн хоёр ба гурван хувьт хэмтэй дуу аялгуунд хэмнэл зохионо. - Дуу дуулахдаа үгийг үеэр таслан хэмнэл зохион хамсран хөгжимдөнө. - Хэмнэлийн бодлого	

1.4г. Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах, өөрийнхөөрөө баяжуулан илэрхийлэх	- Янз бүрийн хэмнэлээр хөгжимт дасгал, хөдөлгөөн хийнэ. - Дөрөвт, наймт хэмжээнээс бүрдсэн хэмнэлийн багцыг баяжуулан тоглоно. - Хөгжмийн аялгууны шинж төрх хэмнэлд тохируулан хөдөлгөөн зохиомжлон хийнэ. - Дууны хэмнэл, утга санаа, хурд, хүчийг мэдэрч түүнд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийнэ. - Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулна. Багшийн анхаарах зүйл: Сургалтыг зохион байгуулахдаа хүүхдийн хөгжил, идэвх, сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх оролцоог хангахын тулд бүтээлч арга, хэлбэрүүдийг уламжлалт сургалтын аргуудтай зохистой хослуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.	Хөгжимт хөдөлгөөн: Б.Өнөржаргал - “Шүдээ угаацгаая” - Б.Цэвээнсүрэн - “Яргуй дэлгэрлээ” - “Хавар”
--	--	--

ХОЁРДУГААР АНГИ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Хөгжмийн дуу авиа		
2.1а. Хүний дуу хоолойн өнгө аясыг сонсож тодорхойлох, сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгддөгийг жишээгээр харуулах	- Хүний дуу хоолойн эгшиглэлтийн өнгө аясыг сонсож танина. - Толгойн болон цээжний дуугаралтыг сонсож тодорхойлно. - Өнгө аясыг сонсож, сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөлтийн өнгө аясыг тодорхойлон хөгжимт хөдөлгөөн зохионо. - Хүний дуу хоолойн дуугаралтыг сонсоод, өнгө аясыг тодорхойлно. Жишээ нь: найзаа олж тоглох, аав, ээж, хүү, охины дүрд тоглож, дуу хоолойн өнгө аясыг тодорхойлох Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсож утга агуулга, хөгжмийн дүрийг хүртэхэд сонсголын ажиглалт чухал үүрэгтэй тул хөгжим хэрхэн, яаж сонсох зөвлөгөөг байнга өгч байх хэрэгтэй.	Техник хэрэгсэл: - Сонсох хөгжим CD, DVD бичлэг
2.1б. Энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон өндрийн зураглал, тулгуур дохиог харж дуулах	- Өндрийн зураглалаар дуулах, гарын дохиотой хослуулна. - Янз бүрийн регистр дэх хөгжмийн дуу авиаг сонсож өөр хооронд нь харьцуулж онцлог ялгаа (өнгө аяс) шинж төрх, хүчийг тодорхойлно. - Өгөгдсөн дүр төрх, шинж байдлыг эгшгийн өндөр нам болон өндрийн зураглалаар илэрхийлнэ. - Сонссон аялгууг дүрслэн бодох улмаар зурах, бичих, гарын хөдөлгөөнөөр дүрслэн илэрхийлнэ. - Амьд ба амьгүй байгалийн юмс үзэгдлийг хөгжмийн дуу авиа, хэмнэл, хурд хүчээр илэрхийлнэ. - Эгшгийн урт богино, өндөр намыг сонсож ялган таних, түүнийг ноотоор бичиж тэмдэглэнэ.	Дуулах дуу: С.Батболд - “Есөн сарын нэгэн” Г.Пүрэвдорж - “Байгаль эхийн хүүхдүүд” Үзүүлэн, ТӨМ: - Туршилт 1, 2, 3... гм (устай лонх, дээс, савлуур-дэвсгэр шугам) - Зурагт үзүүлэн...

	- Эгшгийн өгсөх, уруудах дарааллын зүй тогтлыг олж тогтоон цээжлэнэ. Багшийн анхаарах зүйл: Дан хоолойн дуулалтыг эзэмшүүлэх явцдаа зөв, цэвэр, дуулах арга барил буюу дуулах техникийг эзэмшүүлэх ажиллагааг хослуулна. Дууны уран бүтээл дээр ажиллахдаа дууг сонсгож, тайлбар мэдээлэл хийсний дараа заах үйл ажиллагаа явагдана. Заахдаа дууны хүндрэлтэй хэсгийн ноотыг ажиглуулах, хэмнэлээр алга ташуулах, дуулалтын хүч, өндөрлөг, хэллэг, амьсгааг мэдрүүлэх хэрэгтэй	
2.1в. Өгөгдсөн аялгуунд хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа зохион хөгжимдөх	- Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээн туршина. - Энгийн хэмнэлийг өөрийнхөөрөө баяжуулан тоглоно. - Өгөгдсөн өндрийн зураглалыг ноот бичлэгт хөрвүүлнэ. - Өгөгдсөн аялгуунд хөгжимт хөдөлгөөн зохиомжилж, хэмнэлийн хамсраа хийнэ. - Өөрийн дуртай дууны аялгуунд хэмнэлийн хамсраа хийж, хөгжимдөж үзүүлнэ. - Энгийн хөгжмийн зэмсгээр дуу болон хөгжмийн аялгуунд хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Хэмнэлийг илэрхийлэх дүрс нь аялгууны шинж төрх, дуулах өнгө аястай хэрхэн холбогдож байгааг ажиглуулж харилцан ярилцах хэрэгтэй. Энэ үйл ажиллагааны явцад хүүхэд хэмнэлийн бичиглэлийг харж уншиж, гүйцэтгэх чадварт суралцана. Хөгжимдөхийн өмнө багш хэмжээг урьдчилан өгч өөрийгөө болон бусдыг сонсож зөөлөн, зөв, цэвэр тоглохыг сануулах нь зүйтэй. Хөгжимдөхдөө өөрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлж сурах, хэрэглэгдэхүүнтэй зөв, аюулгүй харьцаж ажиллах, сонирхолд нь тулгуурлан үйл ажиллагаанд хөтлөх зэргийг анхаарч ажиллах нь зүйтэй.	Сонсох хөгжим: - Э.Чойдог “Жалам хар” Хөгжмийн зэмсэг: - Хөгжмийн энгийн зэмсэг, гурвалжин, товшвор, цан, хонх
2.1г. Хөгжмийн зохиолын айзам хэмжээг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр гүйцэтгэх	- Хөгжимт тоглоомоор дамжуулан хөдөлгөөнөө зохицуулах аргад суралцана. - Дуу хоолойн өнгө аясаар сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж, дүрд хувирч тоглоно. - Дүрс бичлэгийг үзээд тодорхой сэдвийн дагуу хөдөлгөөнийг дуурайж хийнэ. (биелгээ, түлээчин) - Хөгжмийн зохиолын хэмнэл, хурд, хүч, утга санааг хөдөлгөөнөөр хийж гүйцэтгэнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаагаар хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, өнгө аяс, айзам хэмжээ, хурд, хүчийг хөдөлгөөн болон зураглал, тэмдэглэгээг ашиглан илэрхийлж болно.	Хөгжимт хөдөлгөөн: - “Шувуухай” - “Бүжин” https://www.youtube.com/watch?v=iFZMe7gqHgc

2. Хөгжмийн эгшиг тэмдэглэгээ		
2.2а. Эгшгийн өндөр намыг ялган сонсож, хөгжмийн дүрийг тодорхойлоход ашиглах	- Өндрийн зураглалаар дуулах, гарын дохиотой хослуулна. - Янз бүрийн регистр дэх хөгжмийн дуу авиаг сонсож өөр хооронд нь харьцуулж онцлог ялгаа (өнгө аяс) шинж төрх, хүчийг тодорхойлно. - Өгөгдсөн дүр төрх, шинж байдлыг эгшгийн өндөр нам болон өндрийн зураглалаар илэрхийлнэ. - Сонссон аялгууг дүрслэн бодох улмаар зурах, бичих, гарын хөдөлгөөнөөр дүрслэнэ. - Амьд ба амьгүй байгалийн юмс үзэгдлийг хөгжмийн дуу авиа, хэмнэл, хурд хүчээр жишээлэн харуулна. - Эгшгийн урт богино, өндөр намыг сонсож ялган таних, түүнийг ноотоор бичиж тэмдэглэнэ. - Эгшгийн өгсөх, уруудах дарааллын зүй тогтлыг олж тогтоон цээжлэнэ Багшийн анхаарах зүйл: Хөтөлбөрт орсноос гадна сонирхолтой, хөгжилтэй, хөнгөн цовоо эсвэл намуун зөөлөн, гуниглуун янз бүрийн шинж төрхтэй зохиол сонгон авч урын сангаа бүрдүүлэх хэрэгтэй.	Хөгжимт хөдөлгөөн: - Эрвээхий https://www.youtube.com/watch?v=8VywkIS7bEw Лаа https://www.youtube.com/watch?v=8PdN6Q9oziQ Хунгийн бүжиг https://www.youtube.com/watch?v=gQyWG-sNu64 https://www.youtube.com/watch?v=SfbmVFivPBA Цасан ширхэг https://www.youtube.com/watch?v=2VAeANSMuqg&list=PLynJMawSMEEWJXoFF7OamYBiOh5kurfAN https://www.youtube.com/watch?v=7IDhbxCTITY
2.2б. G1-C2 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулах	- Ноотыг тоон болон дүрст тэмдэглэгээгээр бичиж, уншиж, дуулна. - Өрөг дараалсан хөдөлгөөн бүхий хялбар аялгууг ноотоор дуулна. - Бүтэн, хагас, дөрөвт ноот ба тэдгээр ноотны зогсоцыг ялган таних, - Зогсоцтой дуу болон дасгал дуулна. Багшийн анхаарах зүйл: Ноотоор дуулах үйл ажиллагааг амжилттай үр дүнтэй болгох нэг арга бол дуулах гэж буй дасгал, аялгуундаа анализ хийж ойлгож, мэдэж дуулах явдал хамгийн чухал юм. Сурагчдыг ноотоор дуулах чадварт сургахдаа чухам юу дуулах гэж байгаа, аялгууны чиглэл хөдөлгөөн хаашаа чиглэж буйд шинжилгээ хийж сургах хэрэгтэй. Иймд бид ноотоор дуулах дуу, дасгалын ноот бичлэгт ажиглалт хийх арга чадварт сургах нь амжилтын эх үндэс гэдгийг мартаж болохгүй.	Дуулах дуу: С.Батболд “Есөн сарын нэгэн” Ц.Ургамал “Хүүхэд нас”
2.2в. G1-C2 эгшгүүдээр давтах, өгсөх, уруудах хөдөлгөөнийг дуулах	- G1-C2 эгшгийн цувааг өгсөх, уруудах чиглэлээр янз бүрийн хэмнэлээр дуулна. (хагас, дөрөвт, наймт, арван зургаат, зогсоцтой) - Дуу авианы өндөр нам, урт богино, өгсөх уруудах хөдөлгөөнийг гарын хөдөлгөөнөөр дүрслэн үзүүлнэ. - Энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон дуулна.	Дуулах дуу: В.Энхжаргал “Тоглоно би” Т.Чимиддорж “Эрх цагаан ишиг” С.Батболд “Шинэ он айсуй”

	Багшийн анхаарах зүйл: Сурагчдыг дуулах үед амьсгааны техникийг анхаарч ажиллана. Амьсгааны техникийг хөгжүүлэхэд амьсгааны дасгал (түргэн хэллэг, хэллэг зүгшрүүлэх дасгал, хэл ба уруулын дасгал) удаавтар хурдтай дуу дасгалыг сонгож болно. Ардын аман зохиолын төрлүүдийг хялбар аялгуунд хадаж, хөг шилжүүлэн дуулуулах нь хоолойн царааг өгсөх чиглэлд өргөтгөх, өнгө тогтоох, өнгө цэвэршүүлэх, амьсгааны багтаамжийг тэлэх ач холбогдолтой.	
2.2г. Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн 2 хоолойгоор хөгжимдөх	- Өгөгдсөн аялгуунд хөгжмийн хамсраа хийж хөгжимдөнө. - Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан гоцлол, цөөхүүл, хоршил, гурвал, дөрвөл хэлбэрийг ойлгож, хөгжимдөнө. - Энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн 2 хоолойгоор, хувилбартайгаар хөгжимдөнө. - Дуу болон хөгжим сонсоод, дуугаралтын болон хөгжмийн зэмсгийн ялгааг харьцуулна. - Тохирох хэмжээнд хэмнэл зохион хөгжмийн энгийн зэмсэг ашиглан 2 хоолойгоор хамсраа хийн хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Хөгжимдөх үйлийн явцад багш ноотны уртасгалт, хэмжээ, хүчтэй сул хувийн харьцаа, зогсоцын тэмдэг зэрэгт анхаарч ажиллах хэрэгтэй. 2 хоолойгоор хөгжимдөхдөө бие биенээ сонсож, хэмнэлийг мэдэрч тоглох шаардлагатай.	Хөгжмийн зэмсэг: - Хөгжмийн энгийн зэмсэг гурвалжин, товшвор, цан зэрэг хөгжим
2.2д. Хөгжмийн зохиолын аялгууны чиглэл хөдөлгөөнийг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлэх	- Аялгууны чиглэлийг олж тогтоох, тохирох хөдөлгөөн хийнэ. - Хөгжмийн хэмнэлд тохируулж, хэрэгсэл ашиглан хөдөлгөөн хийнэ. - Хөгжмийн зохиолын утга агуулга, аялгууны шинж төрхийг хөдөлгөөнөөр илэрхийлнэ. - Хүчтэй сул хувь, аялгууны өгсөх, уруудах, үсрэлттэй чиглэлийг хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсгох үйл ажиллагаа нь хүүхдээс анхаарлын төвлөрөлт, сонсголын ажиглалт, өнгө аяс, аялгууны шинж төрх, хэмнэлийн мэдрэмж, хөдөлгөөний эвсэл, хурдыг шаарддаг. Хүүхдийн өөрийнх нь амьдралын туршлагад тулгуурлан аливаа юмс үзэгдлийг хөдөлгөөнөөр дамжуулан олгох нь илүү үр дүнтэй, сонирхолтой байдаг.	Хөгжимт хөдөлгөөн: - “Завь” https://www.youtube.com/watch?v=GlySxBsJADM - “Ишиг” https://www.youtube.com/watch?v=M-qhBm2KtZl “Хургачин”
3. Хөгжмийн эгшгийн хөдөлгөөн ба аялгуу		
2.3а. Хялбар дуу аялгууг сонсоод эгшгийн өндөр нам, урт богино, аялгууны чиглэл хөдөлгөөнийг зураглах	- Хөгжмийн зохиолыг сонсож аялгууны шинж төрх, айзам хэмжээ, өнгө аяс, хэмнэл хурд, хүчний нийлэмжээр мэдэрч ойлгосноо тайлбарлана. - Хөгжим сонсож, аялгууны шинж төрхийг тодорхойлно. Жишээ нь: хурдан шаламгай, удаан, түгшүүртэй г.м	Дуулах дуу: Ш.Ганхуяг “Хунгийн дуу” Д.Чулуун “Чингисийн Монгол урьж байна” С.Батболд “Миний дотны найз”

	- Байгалийн зургаас аялгууны шинж төрх, хүчийг мэдэрч илэрхийлнэ. - Хөгжим сонсоод дүрслэлийг зураглаж үзүүлнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаагаар хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд, хүчийг илэрхийлсэн зураглал, тэмдэглэгээг ашиглаж болно.	Сонсох хөгжим: - К.Сенсанс “Загас” Үзүүлэн, ТӨМ: - Ноотны дэвтэр
2.36. F1-C1 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулахдаа үсгэн тэмдэглэгээ, зогсоцын тэмдгийг ашиглах	- F1-C1 эгшгийн цувааг янз бүрийн хэмнэлээр дэвсгэр шугамд байрлуулж, үсгэн тэмдэглэгээ ашиглан дуулна. - F1-C1 эгшгийг янз бүрийн дараалалд оруулж, график дүрслэлийн дагуу өгсөх, уруудах давтах дарааллаар ноотоор дуулна. - Энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон дуулна. - Ноотоор дуулахдаа эгшгийн өгсөх, уруудах хөдөлгөөнийг ажиглан хуруугаар дагуулан дуулна. - Төгөлдөр хуур хөгжим хөгжимдөж байна гэж төсөөлөн ширээн дээр хурууны дугаараар тоглож, дуулна. Багшийн анхаарах зүйл: Хүүхдийг бүтээлч үйл ажиллагаанд хамруулдаг дуу, найрал дууг уран сайхнаар амьдруулан, хамт олноороо хөгжмийн утга агуулгыг зөв илэрхийлэхэд сургана. Зэрэг эхлэх, ижил хурдацтай дуулах, багшийн дохиог ойлгох гэх мэт. Мөн багш шинээр дуу заахын өмнө тухайн дуундаа анализ хийж, хүндрэлтэй хэсгийг нь сонгон авна. Үүнд багшийн дуулалт, хөгжимдөлт, тайлбар яриа чухал үүрэгтэй.	
2.3в. Цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлээр 2 хоолойгоор хөгжимдөх	- Цэгтэй ноот, зогсоцыг өгөгдсөн хэмжээний дагуу хэмнэлээр тогшино. - Цэгтэй ноот, зогсоцыг өгөгдсөн хэмжээний дагуу хэмнэлээр 2 хоолойгоор хөгжимдөнө. - Хөгжмийн зохиол болон дууны хэсгээс энгийн хөгжмийн зэмсгээр дагаж хөгжимдөхдөө зогсоц (пауз)-г зөв тоглож сурна. - 2 ба 3 хувьт хэмжээнд цэгтэй ноот, зогсоцын тэмдэг ашиглан хэмнэл зохионо. Багшийн анхаарах зүйл: Хөгжимдөх үйлийн явцад багш ноотны уртасгалт буюу цэгтэй ноот, хэмжээ, хүчтэй сул хувийн харьцаа, зогсоцын тэмдэг зэрэгт анхаарч ажиллах хэрэгтэй. 2 ба 3 хоолойгоор хөгжимдөхдөө бие биенээ сонсож, хэмнэлийг мэдэрч тоглох шаардлагатай. Эгшгийн өндөр намыг хурууны дугаараар дуулах дасгалыг тогтмол хийлгэх нь бишгүүрээр хөгжимдөх бэлтгэл болох юм.	Дуулах дуу: - Б.Цэнджав “Тусч хүү” - С.Батболд “Уярлын долоон эгшиг”

2.3г. Алчуур, тууз, савх, дарцаг зэрэг хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэх	- Агуулга дүр дүрслэлийг хэрэглэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлнэ (алчуур, тууз, савх, дарцаг) - Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт дасгал хийж гүйцэтгэнэ. - Аялгууны хэмнэл, өнгө аяс, хурд хүчинд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэхдээ багш гарын дохиогоор болон тоолж удирдан авч нь чухал юм.	Хөгжимт хөдөлгөөн: - “Мэлхий” https://www.youtube.com/watch?v=R5DR4tAvktM “Дарцагтай дасгал” https://www.youtube.com/watch?v=1zo0gvGD3dA
2.3д. Өгөгдсөн график зураглалаар (өгсөх, уруудах, давтах) аялгуу зохиож харуулах	- Өгөгдсөн аялгуунд хөгжимт хөдөлгөөн зохиомжлон хийнэ. - Сонссон дуу аялгуугаа дотроо дүрслэн бодож, улмаар график дүрслэлээр илэрхийлж зурна. - Өгөгдсөн аялгуунд канон хийж зохиомжлоно. - Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн зохиомжлоно.	Сонсох хөгжим: - К.Сенсанс “Хун” https://www.youtube.com/watch?v=svsnQNbOe_k - “Янзара” - https://www.youtube.com/watch?v=XOAlb0DtAd4
4. Аялгууны шинж төрх		
2.4а. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох, зураглах, амьтдын төрх араншинг илэрхийлэх	- Баавгай, хэрэм зохиолыг сонсоод аялгууг харьцуулж, дүрийг тодорхойлно. - Байгалийн зургаас аялгууны шинж төрх, хүчийг мэдэрч илэрхийлнэ. - Амьтдын төрх араншинг ярилцаж хурд, шинж төрхийг шүлэгтэй холбон тайлбарлана. - Шүлгийг уншаад амьтдын төрх араншинг илэрхийлсэн аялгуу зохионо. Багшийн анхаарах зүйл: Хүүхэд хөгжим сонсоод сэтгэлдээ хийсвэрлэн, дүрслэл үүсгэн ургуулан бодож, сэтгэл хөдлөлийн үүднээс баярлах, гуниглах, эргэцүүлэн дурсах зэрэг сэтгэлийн хөдөлгөөнд ордог. Ийм учраас аливаа хөгжмийг сонсгохдоо өгүүллэг, шүлэг, яруу найрагтай агуулгын хувьд холбон ярих нь сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хөгжүүлэхэд үр дүнтэй арга болно.	Сонсох хөгжим: Ц.Намсрайжав - “Хувдай ишигний паян” Б.Бямбабаяр “Таван төл” Ц.Нацагдорж - “Хөдөөгийн сайхан”
2.4б. C1-C2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа дууны утга агуулгыг ойлгож, өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чадахаа харуулах	- Дууны утга агуулгыг ойлгож, хүчтэй сул хувийг илэрхийлж дуулна. - Дууны утга агуулгыг илэрхийлж, уран яруу дуулна. - Дуулахдаа бусдыгаа сонсож ньуанстай дуулна. - Хялбар дуу, дасгалыг ноотоор дуулж, хэмнэлийн хамсраа хийнэ. - Дуу хоолойн өнгө аясаар сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж дуулна. Багшийн анхаарах зүйл: Дууг үр дүнтэй заахын тулд багш та өөрөө дуугаа сайн мэддэг байх бөгөөд дуугаа сайн судалж, анализ хийж, хөгжимтэйгээ нийлж дадлага хийгээрэй. Мөн тухайн сонгосон дууныхаа зохиогчдыг танилцуулах, түүх домог, аль нутгаас гаралтай, шүлгийн үг нэг бүрийнх нь утгыг ойлгуулан ярих зэргээр тогтмол давтамжтайгаар хичээлдээ ашиглаарай.	Дуулах дуу: Д.Оюунтүлхүүр - “Анхны хичээл”

	Үүнээс гадна дууг заахын өмнө заавал хоолойн дасгал өгч байх хэрэгтэй. Тэднийг дуугаа сайн мэддэг болтол нь дууг давтуулахдаа баг болгон хуваарилах, салаа, анги нийтээр, хөвгүүд охид гэх мэтээр дуулах олон янзын аргыг ашиглаж, өнгө бүрийг цэвэр тод дуулахыг сануулаарай. Ингэж чадвал хүүхэд өөртөө илүү итгэлтэй, дуулж, бүжиглэж, хөгжимдөж сурдаг.	
2.4в. Үгийн үеийг ашиглан хялбар хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимдөх	- Зүйр үгийг уншиж, үеэр хуваан хэмнэлээр тогшино. - Үүссэн хэмнэлийг ноотонд шилжүүлэн хөгжимдөж үзүүлнэ. - Шүлгийг үеэр тасалж нэрлээд алга ташина. Үүссэн хэмнэлээ ноотонд шилжүүлэн хөгжимдөж үзүүлнэ. Багшийн анхаарах зүйл: Зүйр үг ашиглан энгийн хэмнэлийн цээж бичиг хийлгэж хөгжимдүүлнэ. Ингэхдээ зэрэг хөгжимдөхийн тулд багш эхэнд нь тоглож үзүүлэх, анги нийтээр хөгжимдөхөөс өмнө хэмжээ өгч эхлүүлнэ.	Хөгжмийн зэмсэг: - Бөмбөр, савх, товшуур Үзүүлэн, ТӨМ: - Зураглалын янз бүрийн хувилбарууд, дасгалууд, 2 такт ноот
2.4г. Тодорхой сэдвээр (эрвээхий, цэцэг, шувуухай) хөгжимт хөдөлгөөн хийж, дүр төрхийг илэрхийлэх	- Хөгжмийн зохиолын айзам хэмжээ, хүчтэй сул хувийн онцлогийг хөгжимт хөдөлгөөнөөр (гүйх, үсрэх, харайх) илэрхийлнэ. - Сэтгэл хөдлөлөө илэрхийлж, ганцаараа болон анги хамт олноороо дүрд хувирч тоглоно. - Хөгжмийн утга агуулга, шинж төрхөд тохируулан зураглах болон бүжиглэх хөдөлгөөн хийнэ. - Дуу, аялгууг сонсоод хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Багшийн анхаарах зүйл: Аялгууны хэмнэл, өнгө аяс, хурд, хүчинд тохируулан багшийн дохиогоор хөдөлгөөн хийж дүрээ илэрхийлэхэд анхаарна.	Хөгжимт хөдөлгөөн: - “Эрвээхий” https://www.youtube.com/watch?v=hTknEDqMyeM - Ч.Алтансүх “Хулгана” https://www.youtube.com/watch?v=ojO-T-k5Vxo
2.4д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохируулан чөлөөт хөдөлгөөн зохиомжлох	- Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохируулан өөрийнхөөрөө хөдөлгөөн зохиомжлоно. - Хөдөлгөөн хийхдээ хөгжмийн элементүүдийг хэрэглэнэ. Жишээ нь: урт богино хэмнэл, өндөр нам, өгсөх уруудах чиглэл, чанга сул хүч, хурдан удаан темп, өнгө аяс, шинж төрх - Өөрсдийн сурсан дууны аялгууны шинж төрх, хэмнэлд тулгуурлан хөдөлгөөн зохиомжлон, хэмнэлийн хамсраа хийн гүйцэтгэнэ.	Дуулах дуу: - Г.Пүрэвдорж “Байгаль эхийн хүүхдүүд” - Д.Оюунтүлхүүр “Анхны хичээл”

ГУРАВДУГААР АНГИ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдхүүн
1. Өнгө аяс		
3.1а. Хөгжмийн зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган таних, зэмсгүүдийг бүлэглэн тайлбарлах	- Хөгжмийн дуу авиа нь урт богино, өндөр нам, чанга сул, удаан түргэн эгшиглэдэг гэдэг сурагчдын өмнөх ойлголт, мэдлэгт тулгуурлан амьтдын онцлог авир төрхөөр аялгууны үндсэн шинжийг гаргуулан ярилцаж бататгана. - Сурагчдаар өөрсдийн мэдэх олон хөгжмийн зэмсэг нэрлүүлнэ. - Хөгтэй, хөггүй зэмсгийг нэрлэж, ангилна. - Сурагчдын нэрлэсэн хөгжмийн зэмсгүүдийг нэгтгэн жагсаалт гаргана. - Хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэлтийн өнгө аяс, хурд, хүчийг тодорхойлж, холбоно. - Тайлбараа аман болон бичгэн хэлбэрээр хийнэ. - Шаргал талаар Шатрын хүүнүүд Утсан хоолойгоор Уянгалан дуулна. Тэр юу вэ? Хөндлөн мод Хөг эгшигтэй. Тэр юу вэ? г.м оньсогыг тааж зэмсгийн дуугаралттай холбон дүрслэх зэрэг ажлыг бүлгээр, хосоор гүйцэтгэнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаагаар хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд хүчийг илэрхийлсэн график тэмдэглэгээг ашиглаж болно. Сонсох хөгжмийн зохиолууд нь уран сайхны өндөр ач холбогдолтой, хүүхдэд сонирхолтой, сурган хүмүүжүүлэх өргөн цар хүрээтэй, хөгжилтэй, хөнгөн цовоо, намуун зөөлөн, гуниглуун гэх мэт янз бүрийн шинж төрхтэй урын сангаас бүрдэнэ. Хөгжим сонсож хөгжмийн утга агуулга, дүрийг хүртэхэд сонсголын ажиглалт чухал үүрэгтэй тул хөгжим хэрхэн сонсох зөвлөгөөг байнга өгч байх хэрэгтэй.	Сонсох хөгжим: Онгоц, галт тэрэг, машины дуу бичлэг Хөгжмийн зэмсгүүдийн дуугаралттай бичлэг Үзүүлэлэн, ТӨМ: Хөгжмийн зэмсгийн зурагт үзүүлэн
3.1б. Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулах	- Хэмнэл болон аялгууны хөдөлгөөний зураглалыг ноотоор дуулна. - Дууг хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулна. - Үндсэн 7 эгшгийг энгийн хэмнэлүүдтэй холбон хурд, хүчний нийлэмжээр ноотоор дуулна. - Энгийн метр размерт 2/4, 3/4 дохиж дуулна. - Утга санаа дүрслэлийн хувьд ялгаатай дууг зөв илэрхийлэн дуулж тогтооно. - Цэгтэй болон догол хэмнэлийг зөв дуулна.	Дуулах дуу: - Ц.Намсрайжав “Халуун элгэн нутаг” - Ц.Эрдэнэ “Бүүвэйн дуу” - Д.Лувсаншарав “Нараа нараа нааш ир” - З.Хангал “Нарны бүжиг” - С.Батболд “Мөнх тэнгэрийн орон” - Ц.Нацагдорж “Балчир насны нөхөр”

	Багшийн анхаарах зүйл: Дуулах үйл ажиллагааны явцад дуулах үеийн биеийн байршил, өөрийгөө болон найз нөхдийгөө сонсож дуулах, удирдаач, багшийн гарын дохиог хэрхэн харж, унших зөвлөгөөг байнга сануулж ажиллана. Дууг заахад учрах хэллэгийн хүндрэлийг давахын тулд тухайн хүндрэлтэй хэсэгт ажиллахад түргэн хэллэг, амьсгааны дасгал (түргэн хэллэг, хэллэг зүгшрүүлэх дасгал, хэл ба уруулын дасгал) чухал юм.	
3.1в. Бишгүүрээр G-H эгшгийн багтаамжид хөгжимдөх арга барил эзэмшсэнээ харуулах	- Өнгө эгшгийг анхааралтай сонсож Си, Ля, Соль эгшгийг ноотоор хөгжимдөнө. - G-H эгшгийн хооронд ноотоор хөгжимдөнө. - Ноот бичлэгийг ажиглаад, хурууны дугаараар агаарт болон ширээн дээр зөөлөн тогшино. - Хялбар дуу, дасгалын ноотыг ажиглаж, уншиж, бичиж, бишгүүрээр (пианика) хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Энэ үйл ажиллагаагаар сонсголын ба хэмнэлийн дасгал, эгшиг нэрлэх ба ноотоор дуулах дасгал, хэмнэлээр алга таших, цээжээр бичих дасгалыг нилээд оруулж өгөх хэрэгтэй. Мөн хичээлд ашиглах хөгжмийн зэмсэг ховор тохиолдолд эцэг эхтэй хамтран хөгжмийн зэмсэгтэй болох, гарын доорх материал ашиглан хийх зэргээр бүтээлч санаачлагатай хандаарай.	Хөгжмийн зэмсэг: Бишгүүр Даралтат хөгжим Үзүүлэн, ТӨМ: Хөгжмийн зэмсгийн зурагт үзүүлэн Ноотны дэвтэр
3.1г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэлийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлэх	- Өгөгдсөн хэмнэлийн багцлалыг хэрэглэл (дарцаг, савх, тууз, алчуур) ашиглан хөдөлгөөнөөр зохиомжлоно. - Тодорхой сэдвийн дагуу хөгжимт дасгал, аялгуут тоглоом тоглоно. Жишээ нь: Хүүхэлдэй, Өглөө - Дууны хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө жигд гүйцэтгэнэ. - Тодорхой сэдвийн дагуу хөгжмийн хэмнэлд хосоороо бүжиглэнэ. Багшийн анхаарах зүйл: Эгшгийн өндөр нам, урт богино, чанга сул, хурдан удааныг мэдэрч, аялгууны шинж төрх, өнгө аясыг хөдөлгөөнөөр дамжуулан дүрслэх, багшийн дохиог ойлгох, бүжгийн элементийг зөв гүйцэтгэх, хөдөлгөөнөө бусадтай хамтран гүйцэтгэх зэрэг хэрэглэлтэй хөдөлгөөнүүдийг бие даан хийх чадваруудыг эзэмшсэн байна.	Хөгжимт хөдөлгөөн: “Шувуухай” https://www.youtube.com/watch?v=9bq-ZPt9n4w https://www.youtube.com/watch?v=Z86Uzc_Ubmk “Зохицуулагч” https://www.youtube.com/watch?v=nAjL7DQtLYg https://www.youtube.com/watch?v=u0COJZemdtQ
3.1д. Хөгжмийн зэмсгүүдийн дуу авиа үүсгэх арга замыг тодруулж ангилах	- Сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх асуултаар хөтлөнө. - Бөмбөр, цан, шигшүүр, хонх зэрэг хөгжмийн зэмсгүүдийг ажиглаж “Байгалийн үзэгдэл” сэдэвт тоглолт хийнэ. - “Ногоон дэлхийгээ аварья” дүрс билэгийг үзэж байгалийн сүйрлийг хөгжмөөр хэрхэн илэрхийлж байгааг ярилцана. - Хөгжим сонсон аялгууны шинж төрх дүрийг хэрхэн илэрхийлж байгаа талаар ярилцана. - Аялгууны эгшиглэх хүч, өнгө аяс, шинж төрх хэрхэн өөрчлөгдсөн талаар зурагтай холбон тайлбарлана.	Сонсох хөгжим: - “Хоёр ишиг” - “Ногоон дэлхийгээ аварья” https://www.youtube.com/watch?v=3eG_O1wEJ40 Б.Шарав - “Сүхийн цагаан морь” (CD-3)

2. Хурд, хүчдэл		
3.2а. Хөгжмийн уран бүтээлээс өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсож тодорхойлох	- Хөгжмийн уран бүтээлээс (хурд, хүчийг) уран илэрхийллийн аргыг ялгаж сонсоно. - Хялбар дуу, дасгалын ноот бичлэгт өндөрлөг, хэмнэл, аялгууны чиглэл, хүчтэй сул хувь, айзам хэмжээнд ажиглалт хийж сонсоно. - Сонссон дуу, аялгуугаа дүрслэн бодож улмаар график дүрслэлээр илэрхийлж зурж бичнэ. - Аялгууны хөдөлгөөн, хэмнэл, хурд, хүчийг хөгжмийн зохиолоос сонсож тодорхойлно. - Хөгжмийн зохиолын айзам хэмжээ, хүчтэй сул хувийг мэдэрч сонсоно. - Хөгжмийн уран бүтээлээс өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсоод тодорхойлно. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсоод ойлгоно гэдэг нь ухамсартай сэтгэл хөдлөлийн илрэл юм. Иймээс хөгжим сонсох үйл ажиллагааг сэтгэл хөдлөлд тулгуурлан явуулна. Жишээ нь: Э.Чойдог “Жалам хар”, “Бүүвэйн дуу”, “Гэрэлт нарны хүүхдүүд” зэрэг бүтээлүүдээс сурагчид хөгжмийн хэлний илчлэлт нэг бүрийг анхааралтай сонсож, улмаар аялгууны шинж төрх, хэмнэл, хөнгөн цогцог хурд, эгшиглэх хүч, гэрэл гэгээтэй өнгө аясыг мэдэрч сэтгэл хөдлөлөөр уран бүтээлд хандах болно.	Сонсох хөгжим: - Л.Мөрдорж “Хаврын шувууд ирлээ” https://www.youtube.com/watch?v=GlgQq8PaWnU&list=RDGlgQq8PaWnU&start_radio=1&t=179 - Ж.Бизе “Кармен” - Д.Кабалевский “Бүрээч, бөмбөрч” - М.И.Глинка “Вальс” - П.И.Чайковский “Цөмөөхэй” - Н.Жанцанноров “Уралдаан”
3.2б. Ноот бичлэгээс хурд, хүчний тэмдэглэгээг таньж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах	- Ноот бичвэр дэх тэмдэг тэмдэглэгээг таньж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулна. - Утга илэрхийлж уран яруу (ньоанстай) дуулна. - Энгийн хялбар дуу, аялгууг ноотоор уншиж, дуулна. - Дууны агуулгад тохируулан өнгө аясыг зөв илэрхийлж дуулна. - Гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулахдаа бусдын дуулалтыг сонсож, хөг, хэмнэл нийлүүлнэ. - Ноот бичвэрт тэмдэглэгдсэн хурд, хүчний тэмдэглэгээг зөв илэрхийлж дуулна. Багшийн анхаарах зүйл: Ноотоор дуулах үйл ажиллагааг үр дүнтэй болгохын тулд чухам юу дуулах гэж байгаа, дуулах хөдөлгөөн аль чиглэлд, эгшигийн шилжилт хөдөлгөөн ямар зайнд, хаашаа чиглэж буйг ажиглуулах нь чухал. Хөгжмийн утга агуулгыг мэдэрч, зөв илэрхийлж, зөв дуулах аргад сургах үйл ажиллагаа үргэлжилнэ. Цэвэр унисон (дан хоолойн) дуулалтыг эзэмшүүлэх явцдаа дуулах техник ажиллагааг хослуулж ажиллана.	Дуулах дуу: - Б.Цэвээнсүрэн “Яргуй дэлгэрлээ” - Х.Ягаанцэцэг “Мөнх ногоон гацуур”
3.2в. G1-D2 цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг зөв илэрхийлэх	- Ноотоор бичиж, уншиж, хөгжимдөнө. - I октавын G-II октавын D эгшигийн багтаамжид янз бүрийн хэмнэлээр хөгжимдөнө. - G1-D2 цараанд янз бүрийн хэмнэлийн дасгалыг хөгжмийн хамсраатай, хамсраагүй хөгжимдөнө. - Гоцлол, хоршил, гурвал, дөрвөл гэх мэтээр цөөхүүл найрал хэлбэрээр хөгжимдөнө. - Дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлнэ.	Хөгжмийн зэмсэг: - Бишгүүр - Даралтат хөгжим Хөгжимдөх ая: - Ж.Чулуун “Вальс”

	- Сурсан дуу, дасгал аялгууны хурд, хүчийг зөв илэрхийлж бишгүүр (пианика) хөгжмөөр хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Дуу, дасгал, аялгуу ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлж зэрэг эхэлж, зэрэг төгсгөх чадварт суралцах нь чухал үүрэгтэй билээ. Иймээс багш гарын тулгуур дохио болон хөгжимдөж эхлэхийн өмнө хэмжээг тод дуугаар, тоолж удирдан авч явна.	Үзүүлэн, ТӨМ: Хөгжмийн эгшгийн дүрст тэмдэглэгээ бүхий үзүүлэн
3.2г. Хөгжмийн зохиолын агуулга, дүр, өгүүлэмжийн онцлог шинжийг хөдөлгөөнөөр дүрслэх	- Хөгжмийн зохиолын утга агуулга, аялгууны шинж төрхийг хөдөлгөөнөөр илэрхийлж, дүрд хувирч тоглоно. - Янз бүрийн хэмнэлээр хөгжимт дасгал, хөдөлгөөн хийнэ. - Хөгжмийн шинж төрхөд тохируулан бүжиглэх, чөлөөт хөдөлгөөн хийнэ. - Өгсөх, уруудах чиглэлийг хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлнэ. - Хөгжмийн зохиолын утга агуулга, аялгууны шинж төрхийг хөдөлгөөнөөр илэрхийлж, дүрд хувирч тоглоно. - Аялгууны чиглэл хөдөлгөөнийг гарын болон биеийн хөдөлгөөнөөр илэрхийлж дүрслэнэ.	Хөгжимт хөдөлгөөн: - “Тахиа”, https://www.youtube.com/watch?v=WTcyXJ2m2_g - “Бий биелгээ” https://www.youtube.com/watch?v=kRwe1V4IS1w
3.2д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг зураглалаар илэрхийлэх	- Дуу авиаг график зураглалаар дүрслэнэ. - Сонссон хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг янз бүрийн зураас ашиглан зураглалаар дүрслэнэ. - Аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлон утга, агуулгыг зургаар илэрхийлнэ. - Аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн эгшиглэлт, хөгжимдөх хурд, эгшиглэх хүч зэргийг шүлэгтэй хамсран тодорхойлж зургаар илэрхийлнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаагаар хөгжмийн хүртэхүйг хөгжүүлэх нь хөгжмийг олон талаас нь бүрэн тусгахад чухал нөлөөтэй. Тухайлбал: хөгжмийн зохиолын өнгө будаг, хурд хүч, хэмжээ, хэмнэл, аялгууны шинж төрх зэрэг олон шинжийг нэгтгэж эндээс дүр бүтнэ. Энэ дүр хэрхэн бүтэх вэ? орон зайн хүртэхүйн тусламжтайгаар хөгжмийн зохиолын хэлбэр, хэмжээ, багтаамж, аялгууны чиглэл зэргийг тусгана.	Сонсох хөгжим: Л.Мөрдорж - “Түүхт хил” Н.Жанцанноров - “Сэтгэлд шингэсэн говь” https://www.youtube.com/watch?v=Et_or34kvmY Д.Кабалевский - “Циркийн жүжигчин”
3. Хөгжмийн байгууламж		
3.3а. Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, бүрэлдэхүүнийг (гоцлол, цөөхүүл, найрал) тодорхойлох, тайлбарлах	- Аялгуу, регистр (чалх), багтаамж, царааг хөгжмийн бүтээлээс сонсож тодорхойлно. - Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, гоцлол, цөөхүүл, найрал хэлбэрийг тодорхойлно. - Хөгжмийн бүтээлийг сонсож бүрэлдэхүүнийг нэрлэн, ялган танина. - Ялган таньсан учир шалтгаанаа тайлбарлана. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсоод төрөл бүрийн хөдөлгөөнийг хувилбаруудыг зохиомжлон гүйцэтгэх үйл ажиллагаа байх нь зохимжтой.	Сонсох хөгжим: -Ц.Намсрайжав “Баярын жавхаа” https://www.youtube.com/watch?v=BHsZQIH6Lf4 - Г.Бирваа “Уянгын аяз” Үзүүлэн, ТӨМ: Симфони найрал хөгжмийн бүрэлдэхүүн харуулсан зураг

3.3б. Дууны уран бүтээл дэх давталт ялгарамжийг (бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах	- Хөгжмийн зохиолын дүр, утга агуулгыг ойлгож зөв, цэвэр дуулна. - Амьсгааны зарцуулалтыг хянаж алдааг олж илрүүлэх даалгавар гүйцэтгэнэ. - Үг хэллэгийн алдааг олж илрүүлэх даалгавар гүйцэтгэнэ. - Дууны зогсоц, өргөлтийг мэдэрч дуулна. - Сэтгэл хөдлөлөө илэрхийлж, нюанстай дуулна. - Гоцлол, хоршил, гурвал, дөрвөл гэх мэтээр цөөхүүл найрал хэлбэрээр дуулна.	Дуулах дуу: - Монгол ардын дуу “Хургатай хонь” - Г.Эрдэнэчулуун “Цариг цагаан ботго” - Б.Ганхуяг “Дуу шиг хавар”
3.3в. C1-D2 цараанд ноотоор хөгжимдөх, дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлох	- C1-D2 цараанд ноотоор хөгжимдөхдөө тухайлбар, өгүүлбэрийг тодорхойлно. - Тухайлбар, өгүүлбэрийн ялгааг ярилцан тайлбарлана. - I октавын C-II октавын D эгшгийн багтаамжид янз бүрийн хэмнэлээр хөгжимдөнө. - Хүчдэлийн тэмдгийг илэрхийлж хөгжимдөнө. - Дуу, жижиг хэмжээний аязыг ноотоор хөгжимдөхдөө аялгуун дахь давталт ялгарамжийг тодорхойлно.	Хөгжмийн зэмсэг: - Бишгүүр - Даралтат хөгжим Хөгжимдөх ая: С.Батболд “Хувиршгүй тоолол” Үзүүлэн, ТӨМ: Хөгжмийн эгшгийн дүрст тэмдэглэгээ бүхий үзүүлэн
3.3г. Хөгжмийн зохиолын аялгууны бүтэц хэсгийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлэх	- Хөгжим сонсоод төрсөн сэтгэгдэл, бүтээсэн дүрээ хэмнэл, өнгө аяс, хурд хүчтэй холбон зохион бүжиглэнэ. - Хөгжмийн зохиолоос бүтээсэн дүрээ хөдөлгөөнөөр илэрхийлнэ (алхах, үсрэх, гүйх, найгах, ганхах, эрчлэн хурдлах г.м) - Аялгууны бүтцийг мэдэрч аялгууны шилжилт өөрчлөлтийг хөдөлгөөнөөр илэрхийлнэ. - Хэмнэлийн онцлогт тохируулан бүжиглэж, хэмжээг тодорхойлно. - Хялбар аялгуу сонсоод, хөдөлгөөнөөр илэрхийлнэ.	Сонсох хөгжим: - И.П.Ларионов “Калинка” https://www.youtube.com/watch?v=8F_jGXtjN-8 - Г.Цэрэнпил “Төрөлх нутаг”
	Багшийн анхаарах зүйл: Аливаа хөгжмийг сонсгохдоо уран зохиол, яруу найрагтай агуулгын хувьд холбон ярих нь сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хөгжүүлэхэд үр дүнтэй арга болдог.	

3.3д. Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлэх (A1, A2, A3)	- 4/2, 3/4 хэмд хэмнэлийн янз бүрийн багцлал зохионо. - Өөрсдийн сайн мэдэх дууны хэмнэлд тулгуурлан янз бүрийн багцлал зохионо. - Зүйр цэцэн үг, оньсого, хэлц үг ашиглан хэмнэлийн багцлал зохионо. - Өгөгдсөн эгшгээс аялгуу зохиож ноотоор дуулна. - Дууту өгөгдсөн хэмнэлийг гүйцээн бичнэ. - Янз бүрийн хэмнэлийг баяжуулан хувилбарлана. - Марш болон вальсын хэмнэлийг харьцуулан ялгааг илэрхийлж тоглоно. - Өөрсдийн сайн мэдэх дууг хувилбарлан дуулна. Багшийн анхаарах зүйл: Сурагчдын бодож сэтгэж, танин мэдэхийн төлөө тэмүүлэх эрмэлзлийг бий болгоход анхаарна. Өөрийн мэддэг дуу, сонсголд хоногшсон хялбар аялгууг сонгон ашиглах. Эгшиг хоорондын зайн харьцааг мэдрүүлэх график дүрслэл, гарын тулгуур дохио ашиглана.	Дуулах дуу: - МАД “Булигаар хүрэн цүнх” - Д.Мясүрэн “Нар наашаа сүүдэр цаашаа”
4. Хөгжмийн цараа		
3.4а. Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тодруулах, тайлбарлах	- Хөгжмийн бүтээлийг сонсож хэмнэл, эгшиг, өнгө аяс, хурд хүчний нийлэмжээр дүрслэл үүсгэнэ. - Аялгууны шинж төрхийг график дүрслэлээр илэрхийлэн тайлбарлана. - Хөгжмийн бүтээлийг сонсохдоо хэмнэлийг мэдэрч тайлбарлах, мөн зурж бичиж илэрхийлнэ. Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаанд аялгууны хэмнэл, шинж төрх, өнгө аяс, хурд хүчийг илэрхийлсэн зураглал, тэмдэглэгээг ашиглаж болно.	Үзүүлэн, ТӨМ: Ноотны дэвтэр хүүхэд бүрт, харандаа, баллуур, даралтат хөгжим Сонсох хөгжим: - Н.Жанцанноров “Уралдаан” - Ботго
3.4б. Дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг тайлбарлах, удирдаачийн дохиогоор дуулах	- Энгийн хялбар дуу, аялгууг ноотоор дуулах үйлийг гарын тулгуур дохиотой хослуулна. - Ноот бичлэгт ажиглалт хийж, аялгууны чиглэл, хөдөлгөөн (өгсөх, уруудах)-ийг мэдэрч гарын тулгуур дохио ашиглан дуулна. - Ноот бичлэгээс эгшгийн өндөр нам, урт богиныг ялган тодорхойлж, гарын тулгуур дохио ашиглан дуулна. - Дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг тайлбарлаж ярилцана. Багшийн анхаарах зүйл: Дуулах үйл ажиллагааны явцад дуулах үеийн биеийн байршил, өөрийгөө болон нөхдийгөө сонсож дуулах, удирдаач багшийн дохиог хэрхэн харж, ноот унших зөвлөгөөг байнга сануулж ажиллана. Мөн хоолойн өвөрмөц цараатай хүүхдийг онцгойлон анхаарч ганцаарчилан ажиллаж, хөгжүүлэх хэрэгтэй.	Дуулах дуу: - “Цуурай” - Ц.Эрдэнэ “Бүүвэйн дуу”
3.4в. C1-D2 цараанд удирдаачийн дохиогоор хөгжимдөх	- Цэг, нуман холбоосыг ойлгож, багшийн дохилтоор хөгжимдөнө. - Зогсоц, хүчдэлийн тэмдгийг уншиж, багшийн дохилтоор хөгжимдөнө. - Хөгжмийн хамсраатай болон хамсраагүй хөгжимдөнө.	Сонсох хөгжим: Д.Кабалевский “Бүрээч, бөмбөрч” Ашиглах материал: Бөмбөр, тууз, савх мод, алчуур, цагариг г.м

	- Дуу, жижиг хэлбэрийн зохиолын хурдыг утга агуулга, дүрслэлтэй холбон хамсраатай болон хамсраагүй хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Өөрийгөө болон нөхдийгөө сонсож хөгжимдөх, удирдаач багшийн дохиог хэрхэн харж, ноот унших зөвлөгөөг байнга сануулж ажиллана.	
3.4г. Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэлтэй гүйцэтгэх	- Өгөгдсөн хэмнэлийн багцлалыг хэрэглэл (дарцаг, савх, тууз, алчуур) ашиглан хөдөлгөөнөөр зохиомжлоно. - Тодорхой сэдэвт аялгууны хэмнэлийг мэдэрч, хөдөлгөөний шилжилтийг зэрэг зөв гүйцэтгэнэ. - Хөгжмөө анхааралтай сонсон дасгалыг хүүхэд бүр ээлж дараалан янз бүрийн хэрэгсэлээр илэрхийлж бүжиглэнэ. - Хөгжимт дасгалыг бөмбөг, савх, алчуур ашиглан хийж гүйцэтгэх Багшийн анхаарах зүйл: Хөтөлбөрт орсноос гадна сонирхолтой, хөгжилтэй, хөнгөн цовоо эсвэл намуун зөөлөн, гуниглуун янз бүрийн шинж төрхтэй зохиол сонгон авч дарцаг, савх, тууз, алчуур зэрэг янз бүрийн хэрэгсэл ашиглан хэмнэлд тохирох хөдөлгөөн хийлгэнэ.	Хөгжимт хөдөлгөөн: “Дэвүүрт” https://www.youtube.com/watch?v=HMvfZYgdgdQ “Цэцэгс”, https://www.youtube.com/watch?v=CVtET5O_Li4 Сонсох хөгжим: “Хөгжилтэй тариачин” CD DVD бичлэг
3.4д. Өгөгдсөн хэмд хэмнэлийн янз бүрийн багцлал зохиох	- 4/2, 3/4 хэмд хэмнэлийн янз бүрийн багцлал зохионо. - Өөрсдийн сайн мэдэх дууны хэмнэлд тулгуурлан янз бүрийн багцлал зохионо. - Зүйр цэцэн үг, оньсого, хэлц үг ашиглан хэмнэлийн багцлал зохионо. - Зохиосон хэмнэлийн багцаар аялгуу бүтээн бишгүүр хөгжим ашиглан гоцлол болон хамтлагаар хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Үзсэн ноотны хэмжээ болон хэмнэл ашиглан сурагчдаар янз бүрийн ноотны багцлал зохиох тэдгээрийг энгийн хөгжмийн зэмсээр хөгжимдөх аргад багш чиглүүлж өгнө.	Хөгжмийн зэмсэг: - Даралтат хөгжим Бишгүүр хөгжим Дуулах дуу: Үг. Ш.Энхбаяр Ая. А.Балжинням “Тогоруухай”

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Сэтгэл хөдлөл ба хөгжим		
4.1а. Хөгжмийн зохиолын лад хөгийг / мажор, минор/ ялган сонсох, агуулга дүрийг тайлбарлах	- Хөг эгшиглэгээний онцлогийг хөгжмийн уран бүтээлээр дамжуулан сонсож ойлгоно. - Мажор, минорын хөгт бичигдсэн зохиолыг харьцуулан сонсоно. - Зохиолын утга агуулга, аялгууны шинж төрхийг ярилцаж хөг эгшиглэгээг тодорхойлно. - Хөг эгшиглэгээний онцлогийг зохиолын утга агуулга, дууны шүлгийн санаагаар дамжуулан ойлгоно. - Хөг эгшиглэгээний онцлогийг үгээр илэрхийлнэ. Жишээ нь: хүндэтгэлтэй, бадрангуй, хурдан цоглог, баяр баясгалантай, уяруу зөөлөн, бодлогшронгуй, намуун зөөлөн, уянгын, гуниглуун, хатуу чанга, эмгэнэлтэй, давшингуй, тэнүүн тайван гэх мэт - Мажорын хөг эгшиглэгээ А.Вивалди “Хавар”, - Минорын хөг эгшиглэгээ П.И.Чайковский “Аравдугаар сар” зохиолыг харьцуулан сонсож ялгааг тайлбарлана. Багшийн анхаарах зүйл: Хөгжмийн зэмсгийн эгшиглэлтийг сонсож таних, өнгө аясыг тодорхойлох, аялгууны шинж төрх, уран илэрхийллийн арга, зохиолын хурд, хүч, хэлбэр, төрөл зүйлтэй танилцуулах боломжийг бүрдүүлэх ёстой.	Сонсох хөгжим: - Д.Кабалевский “3 охин” https://www.youtube.com/watch?v=6HukYmGpWUg А.Вивалди “Хавар” https://www.youtube.com/watch?v=uD-l9QYUH3I П.И.Чайковский “Аравдугаар сар” https://www.youtube.com/watch?v=f8LXdSr0qV0
4.1б. Мажор, минорын ладад хялбар аялгууг ноотоор дуулах	- Мажор минорын цомнолд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулна. - Дуулахдаа 2/4 хэмжээнд багшийн тусламжтайгаар удирдаачийн схемээр дохино. - Дуулахдаа амьсгааны тэмдэглэгээг зөв хэрэглэж, илэрхийлнэ. - Дуулахдаа бадаг, дахилтын аялгууны өөрчлөлт, хөг солигдол, багтаамж, амьсгаа болон үгийн хуваарилалтыг зөв хийнэ. - Дуулахдаа мажор, минорын эгшиглэгээний онцлогийг мэдрэн ялгааг ярилцана. - Эгшгийн өндөр намыг график зураглалтай холбон сонсож дуулна. Багшийн анхаарах зүйл: Канон, имитаци, секвенцтэй дасгал дуулах, хоёр хоолойн жижиг дасгал, амьсгааны дасгал, ноотоор дуулах дасгалыг уншуулах нь анхаарлаа төвлөрүүлэх, бусдыгаа болон өөрийгөө сонсох чадварт хөтлөх ач холбогдолтой юм.	Дуулах дуу: - С.Батболд “Шинэ он” - М.Хатанбаатар “Цасан охин хаачсан бэ?” - Merry Christmas https://www.youtube.com/watch?v=g-OF7KGyDis Once upon a December https://www.youtube.com/watch?v=oyUBdLm3s9U
4.1в. Мажор, минорын ладад хялбар аялгууг бишгүүрээр (пианика) хөгжимдөх	- Мажор, минорын ладад бичигдсэн дууны ноот бичлэгт ажиглалт хийж, хэмнэлийн зураглалын дагуу хөгжимдөнө. - Мажор, минорын ладад бичигдсэн дууны ноот бичлэг дэх эгшгүүдийн үсрэлт, аялгууны чиглэл хөдөлгөөнийг энгийн хөгжмийн зэмсгийг ашиглан ноотоор хөгжимдөнө. (с-с2)	Хөгжмийн зэмсэг, хэрэглэгдэхүүн: - Ноотны дэвтэр, - Бишгүүр, даралтат хөгжим - Ноот бичлэг бүхий шоо, эвлүүлдэг тоглоом

	- Өгөгдсөн дасгал, богино хэмжээний бүтээлийг ноотоор хөгжимдөнө. - 2/4, 3/4 хэмд өгөгдсөн дасгал, ноот бичлэгт ажиглалт хийж, хөгжимдөнө. - Ноотны ишлэлийг орхигдсон тактад секвенцлэнэ. - 2-4 такт аялгууг канон хэлбэрт бичнэ. - Канон, секвенц, имитацийг ашиглан хэмнэлийг баяжуулан бичиж, дуулж, хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: <i>Хоёр хоолойгоор хөгжимдөх чадварт сургахдаа хэмнэлийн дасгалаас эхлэх нь сайн үр дүнд хүргэнэ. Хэмнэлийн хоёр болон гурван хоолойн дасгал, мөн дуулах зохиолуудтай адил канон, имитаци хэлбэрийг ашиглах, дуунд хэмнэлийн хамсраа хийх, дууны хоёр хоолойн хэсгийн аль нэг хоолойг хөгжимдөх зэрэг энгийн хялбар аргыг хэрэглээрэй</i>	- Ноотны багцлал, бодлогууд - Аялгууны хэсгүүд бүхий тактлаагүй бичвэрүүд, хөгжмийн зэмсгүүд <i>Хөгжимдөх ая:</i> С.Гончигсумлаа “Марш”
4.1г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний өнгө аясыг мэдэрч, сэтгэл хөдлөлөө илэрхийлж бүжиглэх	- Хөгжмийн зохиолын айзам хэмжээ, хурд хүч, чиглэл хөдөлгөөнийг мэдэрч хөдөлгөөн хийнэ. Жишээ нь: давалгаа, цасан хүн, ууланд авирах... - Бүжгийн энгийн элементэд суралцана. Жишээ нь: Вальс 3/4 - Ардын, зохиомжит бүжгийн төрлүүдийг бичлэгээс үзэж, ойлгоно. - Аялгууны шинж төрхийг хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Жишээ нь: Шувуудын бүжиг, Петя чоно 2, Эрвээхий... г.м. Багшийн анхаарах зүйл: <i>Хөдөлгөөнөө хөгжмийн хэмнэл, аялгууны шинж төрхөд тохируулахыг анхааруулж байхыг зөвлөж байна. Бүжгийн утга санаанд сэтгэл хөдлөл, нүүрний хувирлыг зөв хослуулж, илэрхийлж сурахад анхаарлаа хандуулах нь зүйтэй. Бүжгийн энгийн хөдөлгөөн, дасгалуудын видео хичээлүүдээс сургалтад тогтмол ашиглах нь сургалтыг үр дүнтэй явуулахад дэмжлэг болно.</i>	<i>Бүжиглэх бүжиг:</i> - “Дөрвөд биелгээ” https://www.youtube.com/watch?v=pFo_8JuzndY - “Хамтдаа бүжиглэе” (тойрон бүжиг) <i>Үзүүлэн, материал:</i> - Ардын болон цэнгээнт, сонгодог бүжгийн видео https://www.youtube.com/watch?v=cV2pQ5p-FNY https://www.youtube.com/watch?v=6c50x80qTKl
4.1д. Сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэл (баярлах, гуниглах, бодлогошрох) -д тохирох хөгжмийн сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлох	- Өгөгдсөн зохиолын хэсгийн хэмнэлийг тодорхойлон дүр бүтээж зохиомжлоно. - Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг ашиглан хөгжим зохионо. Жишээ нь: хурдан, тэмүүлэлтэй, аяараас чанга... г.м - Сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэл (баярлах, гуниглах, бодлогошрох)-д тохирох хөгжмийн сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлоно. - Өгөгдлийн дагуу аялгуу зохионо. - Аялгууг айзам хэмжээнд оруулна. - Хөгжилтэй бодлого бодно. Багшийн анхаарах зүйл: <i>Өгөгдсөн зохиолын хэсгийн хэмнэлийг тодорхойлон зохиомжлох, зурагт картууд, шоо гэх мэт сонирхолтой тоглоом маягаар аялгууг бүтээлгэх, хамсраа хэмнэл зохиолгох гэх мэтээр бодлого бодох, багцлах, тактлах дадлага ажлыг янз бүрийн аргаар хөтлөх хэрэгтэй.</i>	<i>Сонсох хөгжим:</i> - Ж.Чулуун “Монгол ардын дууны хувилбар аяз” - Э.Григ “Эльфүүдийн бүжиг” https://www.youtube.com/watch?v=Huck3Ernzrw - Ф.Шопен “Прелюди”

2. Уран илэрхийллийн аргууд		
4.2а. Хөгжмийн уран бүтээлээс уран илэрхийллийн хэрэглүүрийг сонсож таних, тодорхойлох	- Сонсох хөгжмөөр дамжуулан илэрхийллийн аргуудыг танина. Үүнд: легато, стаккато, нонлегато, глиссандо - 1-3 тэмдэгтэй мажор, минорын хөгт ноот бичлэгт ажиглалт хийж сонсоно. - Хөгжмийн зохиолыг сонсоод хэмнэл, хурд, хүчээр илэрч байгаа дүрслэл, илэрхийллийг ойлгоно. - Өнгөт /зурагтай/ ном хийх, хөгжмийн зохиолын утга санааг өөрийн үгээр ярих, зурган дүрслэлээр хөгжмөө илэрхийлнэ. - Далайн давалгааг аялгууны шинж төрх, хурд, хүч зэрэг уран илэрхийллийн аргуудаар хэрхэн дүрсэлж байгааг сонсож ярилцана. - Зохиолын гол аялгуу хөгжмийн зэмсгүүдэд дамжин хөгжиж буйг сонсож, ялгана. - Хөгжмийн зэмсгийн дуугаралт, аялгууны хүчдэл, хурд, аялгууны шинж төрхийн өөрчлөлтөөр зохиолын бүтэц хэсгийг тодорхойлно. Багшийн анхаарах зүйл: Зохиолын утга агуулгыг зурагт дүрслэлээр илэрхийлэх, гол аялгууг ноотоор аялуулах, хөгжмийн зэмсэг, аялгууны шинж төрх, хурд, хүчийг тодорхойлохдоо тэмдэг тэмдэглэгээнүүдийг хэрэглэх, утга санаа дүрслэлийг зураг, өгүүлбэр, дүрс, өнгө будгаар илэрхийлэх, хөгжмөө сонсонгоо зурагт дүрслэлийг унших нь илүү сонирхолтой болно.	Сонсох хөгжим: - И.Брамс “Бүүвэйн дуу” (AB) https://www.youtube.com/watch?v=WQnh1VkxxZI - П.И.Чайковский “12 сар” төгөлдөр хуурын цувралын “Цасан доорх яргуй” /4-р сар/- /Энгийн гурван хэсэгт хэлбэр/ https://www.youtube.com/watch?v=-LrbA3_pLI - Ж.Россини. “Вилгелм Телл-удиртгалын төгсгөл https://www.youtube.com/watch?v=hEYPBHS7haM
4.2б. Сонгогдсон бүтээлийг уран илэрхийлэлтэй дуулах	- Лига, легато, цэгтэй ноотыг зөв илэрхийлж дуулна. - Үгийг тод, цэвэр хэлж дуулна. - Хэллэгийн хүндрэлийг хэмнэлтэй хослуулан гүйцэтгэнэ. - Амьсгааны тэмдэглэгээг зөв хэрэглэж сурна. - Амьсгааны тэмдэглэгээ, утга агуулгыг илэрхийлэхэд чухал нөлөөтэйг жишээн дээр мэдэрч, ойлгосноо тайлбарлана. - Гадаад дууны үг хэллэг, амьсгааны техникийг зөв эзэмшүүлэх, дахилтын тэмдэг, 2-3 хоолойн дуугаралтыг зөв дуулна. - “Анастасия” хүүхэлдэйн киноны утга санааг харилцан ярилцаж, үгийг зөв тод хэлж, утгыг илэрхийлж дуулна. - 3/4 хэмжээнд дуулахдаа цэгтэй ноот, тохиолдлын тэмдгийг анхаарч дуулна. - Дуулах хурдыг мэдэрч, тэмдэглэгээг уншиж, зөв илэрхийлж дуулах дадлага хийнэ. Багшийн анхаарах зүйл: Дууны утга санаа, дүрслэлийг илэрхийлэн зөв дуулах тал дээр ажиллахдаа юуны өмнө дууны уран бүтээлд анализ хийж, дэвсгэр хөгийг тодорхойлно. Үүний дараа шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг тодорхойлж, ноот бичлэгээс хөгжимдөх хурд, дуулах хүчдэлийг тодорхойлно.	Дуулах дуу: - Г.Пүрэвдорж “Шинэ өглөө” - Б.Шарав “Хорвоо амгалан байг” - С.Батболд “Анд нөхөдтэйгөө хамт явахад”

	<i>Дараагийн шатанд тухайн хөгт гамм, хоолойн дасгал уншуулан, эгшиглэгээний онцлогийг тодорхойлуулах зорилго тавьж ажиллаарай.</i>	
4.2в. Хялбар дуу аялгууг уран илэрхийлэлтэй хөгжимдөх	- Ноот бичлэгийн хэмнэлийн зураглал, эгшгүүдийн үсрэлт, аялгууны чиглэл хөдөлгөөнд ажиглалт хийж, хөгжмийн зэмсгийг ашиглан ноотоор хөгжимдөнө. (с-с²) - Өгөгдсөн дасгал, богино хэмжээний бүтээлийг ноотоор хөгжимдөнө. - 2/4, 3/4 хэмд өгөгдсөн дасгал, ноот бичлэгт ажиглалт хийж, хөгжимдөнө. - Өөрсдийн сайн мэдэх дуу, аялгууг уран илэрхийлэлтэй хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Зохиолын утга санаа, дүрслэлийг зөв илэрхийлж хөгжимдөхөд анхаарч, хөгжмийн зохиолд анализ хийн дэвсгэр хэгийг тодорхойлно. Багш зэрэг хөгжимдөхөд анхаарч хэмнэлийг нэг такт тоолж эхлүүлнэ.	Хөгжимдөх ая: Хөгжим IV дасгал 1- 5
4.2г. Хөгжмийн зохиолын уран илэрхийллийн хэрэглүүрийг мэдэрч, хөдөлгөөнөөр илэрхийлэх	- Тодорхой сэдэвт тохирсон агуулга дүр дүрслэлийг хэрэгсэлтэй, хэрэгсэлгүй илэрхийлнэ. - Дуут дасгал хийнэ. - Хөгжмийн зохиолоос амьтдын дүрийг тодорхойлон хөдөлгөөнөөр илэрхийлж тоглоно. - Тодорхой сэдвийн дагуу хөгжимт хөдөлгөөн хийнэ (найз нөхөрлөл, хавар) Багшийн анхаарах зүйл: Хөгжмийн хэмнэлийг мэдэрч, хэмнэлд тохируулан бүжгийн дасгал, элементийг хийж сурах, дуулж бүжиглэх, мөр, гарын хөдөлгөөн, хагас суух хөдөлгөөнийг зөв зааж сургах, сэтгэл хөдлөлийг дэмжин бүжиглүүлэх нь бодит чадварыг хөгжүүлэх арга болно.	Хөгжимт хөдөлгөөн: - “Тогорууны бүжиг” https://www.youtube.com/watch?v=M8qprOG2LxY “Таягт” https://www.youtube.com/watch?v=EiQDptNVUPE “Уралдаан” - Хичээлийн завсарлагааны үед хийгдэх дуут бүжиг - https://www.youtube.com/watch?v=u67o5dqMQXE
3. Хөгжмийн энгийн хэлбэрүүд		
4.3а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг ялган таних (AB, ABA)	- Хөгжмийн энгийн хэлбэр болох энгийн хоёр хэсэгт хэлбэр (AB), энгийн гурван хэсэгт хэлбэр (ABA), дахилттай энгийн хоёр хэсэгт хэлбэрүүдийг хөгжмийн зохиолоор дамжуулан сонсож анализ хийнэ. - Хөгжмийн зохиолд анализ хийх дасгал ажлуудыг гүйцэтгэнэ. - Зохиолын хэсгүүдийг сонсохдоо ноотоо уншин AB, ABA хэсгийг хэрхэн тодорхойлж болохыг зурган дүрслэл ашиглан хялбар, энгийнээр харуулна. - Хөгжмийн энгийн хэлбэрийн ноот бичлэгт анализ хийж, тэмдэглэнэ. - A, A1, A2, A3, AB, ABA тэмдэглэгээг ойлгон уншиж, тайлбарлана.	Сонсох хөгжим: - Ж.Россини. “Вилгельм Телл-удиртгалын төгсгөл (ABA)” - И.Брамс. “Унгар бүжиг” (ABA) https://www.youtube.com/watch?v=O192eo9zbT4 - Г.Струве “Хөгжилтэй цуурай” https://www.youtube.com/watch?v=MCzCu7boblw Г.Гладков “Зургийн тухай дуу” https://www.youtube.com/watch?v=OWsvq4MxRNo - Б.Дамдинсүрэн Хэнтийн өндөр ууланд” - https://www.youtube.com/watch?v=OeBUJ7B5q-E

4.3б. Хүүхдийн болон ардын дууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр дуулах	- 2 болон 3, 4 хувьт хэмд ноотоор уншиж, дуулна. - Ноотны зогсоцыг ойлгож, тэмдэглэгээг зөв уншиж, дуулна. - Дуулах дууны хөгт эгшгийн цувааг янз бүрийн хэмнэлээр, өгсөх уруудах чиглэлд дуулна. - Цезур, фраз, үе, өгүүлбэрийг (амьсгаа) зөв илэрхийлж дуулна. - Дууны утга агуулга, дүр дүрслэлийг сэтгэл хөдлөлөөр илэрхийлэн дуулна. Багшийн анхаарах зүйл: <i>Дууны уран бүтээлийг сонгоход бадаг эсвэл дахилт нь хоёр хоолойгоор бичигдсэн, мөн жижиг хэмжээний хоёр хоолойн дуу байх нь зохимжтой. Мөн хүүхдийн болон ардын дууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр дуулахаар сонгож болно.</i>	Дуулах дуу: - З.Хангал “Цэцэг юмуу би” - Г.Эрдэнэбаатар “Хэнз хурга” - Л.Даваахүү “Нэг ангийнхан” - Р.Энхбазар “Өглөөний тухай дуу”
4.3в. Хялбар дуу аялгууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр хөгжимдөх	- Ноотоор дасгал дуулах, хоёр хоолойн дасгалыг дуулах дадлага хийх, хоолой салж байгаа хэсэгт бие биенээ сонсож дуулна. - Өгөгдсөн зохиолын хоолой тус бүрийг ноотоор хөгжимдөж сурна. - Дууны утга агуулгыг ярилцаад хурдыг тодорхойлоод хөгжимдөнө. - Хосоор, багаараа сайн мэдэх дуугаа харилцаа болон хөөцөл хэлбэрээр хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: <i>Багш хоёр хоолойн дасгал, зохиолын хэсгийг сурагчидтай хамсрахдаа бишгүүр, даралтат үлээвэр хөгжим, энгийн зэмсгүүдийг ашиглан өөрөө нэг хоолойг хөгжимдөх зэргээр идэвхитэй үйл ажиллагааг явуулаарай.</i>	Хөгжимдөх ая: - Торгууд ардын дуу “Тоохуу нэгэн хос” - Б.Цогоо “Шөнө” “TWINKLE TWINKLE” “Тооройн цагаан элс” “Эхийн дуу”
4.3г. Тодорхой сэдэв, дүрийг илэрхийлэх хөгжмийн зохиолын сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлох	- Өөрийн сайн мэдэх дууны хэмнэлийг сонсоод баяжуулан хөдөлгөөн зохионо. - Тодорхой сэдэв, дүрийг илэрхийлэх хөгжмийн сонголт хийж, хөдөлгөөн зохиомжлоно. - Тухайн хөгжмийн зэмсэгт зориулан хэмнэлийн хувилбар хийн өөрчлөх, сонсох хөгжмөөр дамжуулан хэмнэлийн багцлал зохионо. - Бүжгийн энгийн элемент бүхий дасгалыг зохиомжлоно. - Хөгжмийн дүр дүрслэлийн хэрэглүүрүүдийг ашиглан хөдөлгөөн зохионо. Жишээ нь: өглөө, амьтад... г.м Багшийн анхаарах зүйл: <i>Утга санаа дүр, дүрслэлийг илэрхийлэн бүжиглэхдээ хэрэгсэлтэй болон хэрэгсэлгүй гүйцэтгүүлж болно. Бүжгийн дасгалын элементүүдийг хийхдээ хэрэгслүүдийг зөв барих, уран илэрхийлэлтэй гүйцэтгэх, өгөгдсөн сэдэв, зааврын дагуу бүжгийг хийж сурахад багш туслан чиглүүлэх үүрэгтэй.</i>	Үзүүлэн, ТӨМ: - CD, DVD – бичлэг - Бүжгийн дасгалын заавар, зураглал, дасгал https://www.youtube.com/watch?v=olkQjwFu1s - Бүжгийн ноот, үг, бичлэг, бүжгийн хөдөлгөөнүүд https://www.youtube.com/watch?v=i13Yex4ffbw https://www.youtube.com/watch?v=u9QGE1qv1A4 - Бүжиг, зохиомжит бүжгийн аязууд - Ноотны багцлал

4.3д. Хөгжмийн хэлний хэрэглүүрийг ашиглан сэтгэл хөдлөлийг илэрхийлэх, тодорхой дүрслэл үүсгэх	- Хөгжмийн дүр дүрслэлийн хэрэглүүрүүдийг ашиглан хөгжим зохионо. Жишээ нь: байгаль ба хөгжим... г.м - Өгөгдсөн зохиолын хэсгийг сонсож тодорхой дүрслэл үүсгэх, утга санааг тодорхойлон дүр бүтээж зохиомжлоно. - Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг ашиглан хөгжим зохионо. Жишээ нь: хурдан, тэмүүлэлтэй, аяараас чанга... г.м - Бичиж найруулсан зохиолдоо хүчдэлийн тэмдгүүдийг хэрэглэнэ. - Хөгжилтэй бодлого бодно. - “Хэмнэл” аялгуут тоглоом тоглож мэдлэгээ сорино. Багшийн анхаарах зүйл: Өгөгдсөн ноот, хэмнэлийг баяжуулан тоглох, жижиг хэмжээний зохиол хэмнэлийн хамсраа хийж бичих, секвенцээр бичигдсэн зохиолын нэг айзам хэмжээг ноотлуулах зэргээр хялбар дасгалуудыг хийлгэх, эгшгийн өгсөх, уруудах хэлбэрт секвенц бичүүлэн сонсгох, зохион найруулсан бүтээлд нэр өгүүлэх, үгтэй холбох зэрэг даалгаврыг гүйцэтгүүлж болно.	Үзүүлэн, ТӨМ: - Ноот бичлэг бүхий шоо, эвлүүлдэг тоглоом - Ноотны багцлал, бодлогууд - Аялгууны хэсгүүд бүхий тактлаагүй бичвэрүүд, хөгжмийн зэмсгүүд
4. Хөгжмийн зохиолын дүр дүрслэл		
4.4а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг агуулгатай холбон тайлбарлах	- Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг энгийн хэлбэртэй холбон тайлбарлана. - Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг ашиглан хөгжим зохионо. Жишээ нь: хурдан, тэмүүлэлтэй, аяараас чанга... г.м - Өгөгдлийн дагуу айзам хэмжээнд тохируулан аялгуу зохионо. - Зураг, ноот, аялгууны шинж төрх илэрхийлсэн үг, хүчдэлийн тэмдэг зэрэг хөгжмийн тэмдэг тэмдэглэгээний тусламжтайгаар хөгжмийн дүр бүтээнэ. Багшийн анхаарах зүйл: Орон зайн хүртэхүйн тусламжтайгаар хөгжмийн зохиолын хэлбэр, хэмжээ, багтаамж, аялгууны чиглэл зэргийг тусгана. Харин цаг хугацааны хүртэхүйн тусламжтайгаар хөгжимдөх хурд, хэмнэлийг мэдэрдэг.	Сонсох хөгжим: -Ф.Шуберт, В.И.Гёте “Ойн хаан” баллада https://www.youtube.com/watch?v=yM_LRTDI5N8 -Римский-Корсаков “Салтан хааны үлгэр” “Гурван гайхамшиг” https://www.youtube.com/watch?v=mySbmLIMLmU И.Брамс “Бүүвэйн дуу” https://www.youtube.com/watch?v=P6z1NuEnQmc -К.Шуман “Вариаци” https://www.youtube.com/watch?v=81WW9yMUS1k
4.4б. Ноот бичлэгт ажиглалт хийж, дууны утга агуулгыг илэрхийлэн хоёр хоолойгоор дуулах	- Ноотоор хоёр хоолойн дасгалыг дуулах дадлага хийх, хоолой салж байгаа хэсэгт бие биенээ сонсож дуулна. - Хоолой тус бүрийг ноотоор дуулж сурна. - Дууны утга агуулгыг ярилцаад, хурдыг тодорхойлж дуулна. - Хэмнэлийн хамсраа хийж дуулна. - Ноот бичлэгт ажиглалт хийж дууны багтаамжийг тодорхойлж, дуулна - Ноот бичлэгээс амьсгааны тэмдгийг таньж, зөв дуулна.	Дуулах дуу: - С.Батболд “Говийн өглөө” - З.Хангал “Цэцэг юм уу би” - Х.Сэргэлэн “Хөх яргуй” - Г.Пүрэвдорж “Түүдэг гал”

	Багшийн анхаарах зүйл: 2 хоолойгоор дуулах дасгалын төрлүүд нь хоорондоо эрс ялгарамжтай байвал сурагчид хурдан хүлээж авна. Тухайлбал: а. 2 хоолой эсрэг чиглэлийн хөдөлгөөнтэй б. Нэг хоолой хөдөлж байхад нөгөө хоолой барилттай дуулах гэх мэт. Мөн канон, секвенц, имитаци дуулах нь сурагчдад сонирхолтой байгааг зогсохгүй ухамсарт хандлага төлөвшүүлэх ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл өөрийгөө сонсож зөв дуулахын зэрэгцээ, нөгөө хоолойг давхар сонсон түүнд нийцэж дуулах ба анхаарлын төвлөрөлт, хуваарилалтыг хөгжүүлдэг.	Үзүүлэн, ТӨМ: - Хоёр хоолойн дасгалууд - Хэмнэлийн хамсраа хийх дасгалууд - Хөгжмийн онолын тэмдэг, тэмдэглэгээ бүхий үзүүлэн
4.4в. Хялбар дуу, аялгууны айзам хэмжээ, чиглэл хөдөлгөөнийг тодорхойлж, хоёр хоолойгоор хөгжимдөх	- Хялбар дуу, аялгууг хоёр хоолойгоор гоцлол, цөөхүүлээр хөгжимдөнө. - Хялбар, дуу аялгууг хамсарч болон найрлаар хөгжимдөнө. - 2 хоолойн богино хэмжээний зохиолыг ноотоор, цээжээр уншиж хөгжимдөнө. - Өгөгдсөн сэдвийн дагуу дүр бүтээнэ. Жишээ нь: морин уралдаан, дуучин, хөгжимчин г.м - Бишгүүр хөгжмийн зэмсгийг ашиглан C-C² ноотоор хөгжимдөнө. - Сурсан дууныхаа дахилтыг хамсраа хийн хөгжимдөнө. - Жижиг хэлбэрийн аялгууг бишгүүр, даралтат хөгжмөөр хөгжимдөнө. - Багшийн дохиогоор хөгжимдөнө. Жишээ нь: хэмнэлийн дасгалыг хөгжмийн энгийн зэмсгээр, бишгүүр, даралтат хөгжмөөр баг болон хуваагдаж хөгжимдөнө. - Гоцлол, цөөхүүл, хоршил, гурвал, дөрвөл хэлбэрээр хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Багш хоёр хоолойн дасгал, зохиолын хэсгийг сурагчидтай хамсрахдаа бишгүүр, даралтат үлээвэр хөгжим, энгийн зэмсгүүдийг ашиглан өөрөө нэг хоолойг хөгжимдөх зэргээр идэвхтэй үйл ажиллагааг явуулаарай. Ангид байх хөгжмийн зэмсгийг ашиглан хэмнэлээр хөгжимдөх, жижиг хэлбэрийн аялгуунд хэмнэлийн хамсраа хийх, мөн бишгүүр хөгжмөөр хөгжимдөхдөө маш алгуур, яаралгүй тогтож ажиллах шаардлагатай.	Хөгжмийн зэмсэг: - Бишгүүр хөгжим - Даралтат хөгжим Хөгжимдөх ая: - Ц.Сүхбаатар “Би цэцэг тарьсан” - С.Батболд “Хичээлийн завсарлагааны дуу” - Торгууд ардын дуу “Агсал” - Сурах бичиг I Дасгал 1 - Ц.Сүхбаатар “Жигмэд тогмид хоёр”
4.4г. Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг график дүрслэл, зурах, бичих, жүжигчилэх зэргээр илэрхийлэх	- Тодорхой сэдвийн дагуу хөгжимт хөдөлгөөн хийнэ. (найз нөхөрлөл, хавар) - Багшийн заавар болон дүрс бичлэгийн дагуу бүжгийн хөдөлгөөнийг хийж гүйцэтгэнэ. - Тууз, бөмбөг, шүхэр, алчуур, таяг зэрэг хэрэгсэлтэй бүжиглэнэ. - Өгөгдсөн сэдэв, зааврын дагуу хөгжимт хөдөлгөөн хийнэ. (ойд, үүл, мөрөөдөл гм) - Хөгжим сонсоод агуулга, дүр дүрслэлийг график дүрслэл, зурах, бичих, жүжигчилэх зэргээр илэрхийлнэ.	Ашиглах материал: - Алчуур, тууз, савх мод Үзүүлэн, ТӨМ: - Ноотны дэвтэр, харандаа, баллуур - Тэмдэг, тэмдэглэгээ бүхий үзүүлэн Техник хэрэгсэл: CD, DVD – бичлэг

	Багшийн анхаарах зүйл: Хөгжим сонсох үйл ажиллагаагаар зохиолын аялгууны хэмнэл, шинж төрх, өнгө аяс, хурд, хүчийг илэрхийлсэн зураглал тэмдэглэгээг ашиглаж болно. Хөгжмийн зохиолын төрөл, гоцлол, цөөхүүл, найрал хөгжмийн бүтээл, бүрэлдэхүүнийг дүрс бичлэгээс сонсохдоо зурагт үзүүлэнгүүд, тарааж өгөх дасгалууд, асуулт даалгавруудыг олон хувилбартай хийх хэрэгтэй.	
--	---	--

ТАВДУГААР АНГИ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Аялгуу		
5.1а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг (AB, ABA, ABC, A1, A2, A3) тодорхойлох, ялган таних	- Хөгжмийн зохиолыг сонсож, анализ хийн агуулга хэлбэрийн нэгдлийг зурган дүрслэл ашиглан хялбар, энгийнээр ойлгоно. - Фа, соль эгшгээс мажорын цомнол байгуулах, түүнийгээ тайлбарлана. - Ре, ми эгшгээс минорын цомнол байгуулахдаа хувиргалын тэмдгүүдийг ашиглана. - Төгөлдөр хуур хөгжмийн даруулуудыг ажиглан, хувиргалын тэмдэгтэй холбоно. - Ноот бичлэгийг ажиглан гурвал эгшгүүд буюу аккордыг байгуулж, сонсоод ярилцана. - Д.Кабалевскийн “Хөгжилтэй наадаан” зохиолыг сонсохдоо зохиолын агуулга дүрслэл, бүтэц хэлбэр, аялгууны чиглэл хөдөлгөөнийг зураглах аргыг хэрэглэнэ. Багшийн анхаарах зүйл: Сонсголоор дамжуулан хүртэхийн зэрэгцээ харааны тусламжтайгаар давхар хүртэх үйл ажиллагаа буюу хараа сонсголын нэгдмэл үйл явц, хүүхдийн ой тогтоолтыг хөгжүүлэхэд мөн хөгжмийн хэл, утга илэрхийллийн гол хэрэглүүр аялгуу, түүний бүтэц, чиглэл хөдөлгөөнийг ойлгоход оновчтой арга болно.	Сонсох хөгжим: - Э.Григ “Уулын хааны агуйд” https://www.youtube.com/watch?v=KySK917oYTc Д.Кабалевский “Хөгжилтэй наадаан” -Ж.Чулуун “Уулын горхи” https://www.youtube.com/watch?v=N7I-c8fztsY
5.1б. Диатоник, пентатоник мажор, минорын ладад дуулж ялгааг тайлбарлах	- Хөгжмийн эгшгийн дүрст, тоон, үсэгт илэрхийллийг сэргээн санаж, хэрэглэнэ. до, ре, ми, фа, соль, ля, си, I, II, III, IV, V, VI, VII, с d e f g a h - Хөгжмийн эгшгүүдийг эрэмбэлж, сонсоно. - I өрөг буюу тоникийн тухай ойлголттой болно. - До, ля-аас эгшгийн цуваа байгуулна. I өрөг нь до - с-с², I өрөг нь ля - (а-а²) г.м - Эгшгийн цуваанаас тогтвортой, тогтворгүй эгшгүүдийг олж тодорхойлно. (I, III, V - тогтвортой өрөг) - Dur (мажор), moll (минор)-ын цомнолыг сонсож, танина. Жишээ нь: с dur- өнгөлөг цоглог, а moll- уян зөөлөн	Дуулах дуу: - Б.Шарав “Багш та” -Л.Галмандах “Бага насны он жилүүд” -Ц.Сүхбаатар “Ээждээ би хайртай” -С.Батболд “Аяны шувууд ирлээ”

	- Мажор минорын хөгийг таньж тодорхойлох, ялгааг харьцуулан ярилцана. - Эгшгийн эрэмбэ, цомнол, интервал, аккорд байгуулан сонсож, дуулна. - Энгийн болон нийлмэл хэмжээнд хэмнэлийг дуулж, тодорхойлно. Жишээ нь: 2/4, 3/4, 4/4, - Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг сонсож ойлгох, сэтгэл хөдлөлөөр дуулна. Багшийн анхаарах зүйл: Дуулах үйл ажиллагаан дээр сонгон авсан уран бүтээлийнхээ агуулгатай холбон дууны хурд, хүч ямар байгаа, хөгжмийн зохиолч яагаад тухайн хурд, хүчийг сонгон авсан, хэмнэлийн зураглал зохиолын дүр дүрслэлд ямар үүрэгтэй, аялгууны чиглэл хөдөлгөөн юу илэрхийлэв? гэх зэргээр хөгжмийн хэллэг нэр, томъёог тайлбарлан ойлгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Мөн агуулгыг эзэмшүүлэхдээ сонсголын ба хэмнэлийн дасгал, эгшиг нэрлэх ба унших дасгал, хэмнэлээр хөгжимдөх ба бичих дасгал түлхүү оруулах нь зүйтэй.	
5.1в. Утга санаа илэрхийлж уран яруу (ньюанстай) гоцлол болон найрал хэлбэрээр хоёр хоолойгоор хөгжимдөх	- Багшийн тоглох аялгууг сонсоод динамикийн тэмдгүүдээс оновчтойг сонгон ноот бичлэгт зөв байрлуулна. - Тодорхой сэдвээр бичигдсэн аялгууг хөгжимдөхдөө утга санааг илэрхийлэх хурд, хүчний өөрчлөлтийг оновчтой сонгон хэрэглэнэ.. Жишээ нь: ✓ Төрсөн өдрийн баярын дуу ✓ Бүүвэй ✓ Аялал ✓ Эх орон ✓ Гуниг - Өгөгдсөн зохиолын утга санааг илэрхийлж, уран яруу (ньюанстай) гоцлол болон найрал хэлбэрээр хоёр хоолойгоор хөгжимдөнө. - Гоцлол болон найрал хэлбэрээр хөгжимдөхдөө бусдыг болон удирдаачийн дохиог анхаарна. Багшийн анхаарах зүйл: Гоцлол ба найрал хөгжмийн хамтлагт хөгжимдөх дур сонирхлыг бий болгох, удирдаачийн схемийг ойлгож мэдэрдэг, хэмнэлийн болон хөгжмийн хамсраа хийж чаддаг, түүнийгээ гэр бүл болон сургууль, ангидаа уран бүтээл болгодог байх, ноотоор, хэмнэлээр, утга санааг илэрхийлэн хөгжимдөх, хэмнэл, ноотыг унших дасгал болон хөгжимдөх дадлага ажлыг олон дахин хийлгэх хэрэгтэй. Хүүхдүүд зөвхөн “тэр хөгжмийн зэмсэг байна” гэж өнгөц танихдаа биш харин хөгжмийн зэмсгийн бүтэц, зохион байгуулалт, дуугаралтын онцлогийг судлан таньж мэдсэнээр тухайн хөгжмийн зэмсгийн талаар бүрэн ойлголттой болно. Хөгжмийн зэмсэгтэй хэдий чинээ эрт танилцуулна, сонссон хөгжмөө ойлгож ухаарах хүүхдийн чадвар төдий чинээ хурдан хөгждөг.	Хөгжимдөх ая: - Д.Оюунтүлхүүр “Анхны хичээл” - Ж.Оффенбах “Бүжиг” - “Анхны хичээл” - “Би цэцэг тарьсан” - “Ботго”

5.1г. Тодорхой сэдвийн (галт тэрэг, уралдаан, бүүвэй гэх мэт) дагуу хэмнэлийн зохиомж хийх	- Хоёр ба гурван хоолойгоор ноотоор хөгжимдөнө. - Хөгжмийн энгийн зэмсэг бүтээх, өөрсдийн бүтээсэн зэмсгээр хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөнө. Жишээ нь: хушга ясыг ашиглан зэмсэг бүтээх... г.м - Тодорхой сэдвээр хос хосоороо хэмнэлийн зохиомж хийнэ. - Өгөгдсөн хэмжээнд хэмнэл зохионо. - Янз бүрийн хөгжмийн зэмсэг ашиглан хэмнэлийн зохиомж хийнэ. - Амьтдын шинж төрхийг ярилцан хэмнэл болон өнгө эгшиглэгээг тодорхойлж, зохиомж хийнэ. Жишээ нь: Зааныг аль регистрт, ямар хэмнэлээр, хэрхэн дүрсэлж байгааг хөгжмийн зохиолоос сонсож анализ хийнэ. - Ж.Фужикийн “Тэмцэгчдийн марш” зохиолыг сонсгоод зурган мэдээллийн аргаар зохиолын үндсэн хэмнэлийн зураглалын дагуу зохиомж хийнэ. Багшийн анхаарах зүйл: Өмнөх улирлуудаар үзсэн дасгал, хэмнэл, зохион найруулсан аялгуу, дуу, хөгжмийн бүтээлд хийсэн хэмнэлийн хамсрааг гоцлол болон хамтлаг, найрал дуу гэх мэт бүрэлдэхүүнд найруулан тоглолт зохион байгуулах, багштайгаа хамтран ангийн концерт зохион найруулах боломжтой юм.	Үзүүлэн, ТӨМ: - Ноотны багцлал, бодлогууд, аялгууны хэсгүүд бүхий тактлаагүй бичвэрүүд, хөгжмийн зэмсгүүд
2. Хөг эгшиглэгээ		
5.2а. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг (пентатоник, диатоник) сонсож тодорхойлох	- Дууны ноот бичлэгт ажиглалт хийж, аялгууны давталт, ялгарамжийг олж тогтооно. - Аялгууны давталт ялгарамжийг график зураглалын дагуу сонсож тодорхойлно. - Аялгууг хэвээр хадгалан айзам хэмжээ өөрчлөгдөхийг ноот бичлэгээс ажиглаж, сонсоно. (А, А₁, А₂) Жишээ нь: дасгал юугаар адил болохыг сонсож ажиглах, дүрслэл хийх, хэмнэлийг тодорхойлно. - Ноот бичлэгийг ажиглан сонсголын цээж бичиг хийнэ. - Амьтдын шинж төрхийг ярилцан хэмнэл болон өнгө эгшиглэгээг тодорхойлно. Жишээ нь: зааныг аль регистрт, ямар хэмнэлээр, хэрхэн дүрсэлж байгааг хөгжмийн зохиолоос сонсож анализ хийнэ. - Багшийн тоглохыг анхааралтай сонсож ажиглах, эгшиглэгээний онцлог, хэмнэл, хурд, хүчийг тодорхойлно. - Цомнол, айзам хэмжээг тодорхойлно. Багшийн анхаарах зүйл: Хөгжмийн хэллэг, нэр томъёоны тухай ойлголтуудыг хөгжмийн зохиол бүтээлийг сонсгох аргаар гүнзгийрүүлэх нь хамгийн чухал. Сурагчид хөгжим сонсохдоо сурах бичиг болон үзүүлэн дэх ноотыг дагуулан харж, хэсэгчлэн ажиглалт хийж болно. Гэхдээ энэ аргыг үргэлж хэрэглэх нь хүүхдийн сонирхлыг бууруулах талтай. Сурагчид өөрийнхөө түвшинд хөгжмийн зохиолд задлан шинжлэл хийж сурахад багшийн оролцоо чухал юм.	Сонсох хөгжим: - И.С.Бах Оркестрт зориулсан сюита №2 (си минор) - Badinerie https://www.youtube.com/watch?v=hVARLQoIFk0 - К.Сен-Санс “Амьтдын багт наадам” – Заан https://www.youtube.com/watch?v=fye9Kp1GK9Y - When Christmas comes to town https://www.youtube.com/watch?v=dtSzN3TkQsl&list=RDdtSzN3TkQsl&start_radio=1

5.26. Эгшиг зохиролоор (консонанс, диасонанс интервал) дуулж онцлогийг тайлбарлах	- Фа мажор, Ре минорын дэвсгэр хөгт сонсголын ажиглалт хийж, харьцуулан ноотоор дуулна. Жишээ нь: “Гацуурхан”, “Агсал” - Соль мажор, ми минорын хөгийг ажиглаж, тэр хөгт бичигдсэн дууг дуулна. Жишээ нь: “Начин шонхор хоёр”, “Тэгвэл хоёулаа” - Гадаад дууны үг хэллэг, өргөлт, акцентийг зөв цэвэр илэрхийлж дуулна. - Аялгууны хэсгүүдийг (фраз-тухайлбар, өгүүлбэр) зөв илэрхийлж (амьсгаа) дуулна. - Хувиргалын тэмдгүүдийг таньж, зөв илэрхийлж дуулна. - Хөгжмийн зохиол бүтээлээр дамжуулан дуулаачийн болон дан хөгжмийн төрөл зүйлээс сонсож анализ хийнэ. - Дүрст бичлэг болон аудио бичлэг сонсох, зохиолын ноот бичлэгийг ажиглаж ноотоор уншина. - Хөгжмийн аялгууны хүчдэлийн өөрчлөлтийг мэдэрч тодорхойлно.	Дуулах дуу: - Ц.Эрдэнэ “Алтан навчис даараа юм уу” - С.Батболд “Гэрэлт нарны хүүхдүүд” - Б.Цогоо “Амар сайн уу шинэ жил минь”
5.2в. Бүжгийн энгийн элемент бүхий дасгалыг гүйцэтгэх	Багшийн анхаарах зүйл: Ноотоор дуулах дуу, дасгалын ноот бичлэгт ажиглалт хийх чадварт сургах нь амжилтын эх үндэс гэдгийг мартаж болохгүй. Жишээ нь: Дасгалыг дуулахдаа “Аливаа дуу, дасгалын аялгуу өгсөж, уруудах болон давалгаа маягийн олон янзын чиглэл хөдөлгөөнийг үүсгэдэг” гэсэн ойлголт мэдлэгтээ үндэслэн тухайн дуулах гэж буй ноот бичлэгтээ ажиглалт хийж, эгшгүүдийн хөдөлгөөн хаашаа чиглэснийг мэдснээр хоолойгоо зөв удирдаж дуулна. - Тодорхой сэдвээр бүжиглэх Жишээ нь: Хөгжмийн аянд 2 гарын хөдөлгөөнөөр навчсыг дүрслэх, бүжгийн энгийн элементэд суралцана. - Хөгжмийн дүр дүрслэлийг хөдөлгөөнөөр хэрхэн илэрхийлж болохыг ойлгож дүрслэнэ. - Хөгжмийн зохиолын айзам хэмжээ, хүч, чиглэл хөдөлгөөнийг мэдэрч өгөгдсөн зураглалын дагуу бүжгийн хөдөлгөөнийг хөгжмийн аянд тохируулан бүжиглэх, бүжгийн хөдөлгөөн хийнэ. Жишээ нь: “Таягт бүжиг”, “Тоглоом” нэртэй хөгжимт бүжиг - Зохиомжит бүжгийн хөдөлгөөнийг зааврын дагуу хийнэ. - Бүжгийн хөдөлгөөнийг өөрсдөө бие даан болон багшийн заавраар хичээлийн анги танхимд хийнэ. - Хөдөлгөөний шилжилт холболтыг зөв цэвэр гүйцэтгэж сурна. - Ардын болон цэнгээнт, орчин үеийн бүжгийн элементүүдийг цахим хэрэглэгдэхүүн ашиглаж сурна. - Тодохой сэдвээр бүжиглэнэ. Жишээ нь: Цасны бүжгийн хөдөлгөөнүүдийг багшийн заавраар хийнэ. - Хөгжмийн аянд гар, хөл, биеийн хөдөлгөөнөөр утга санааг дүрсэлж бүжгийн энгийн элементэд суралцана.	Хөгжимт хөдөлгөөн: - “Алчууртай бүжиг” - “Ботго” Үзүүлэн, ТӨМ - Видео хичээлүүд - Бүжгийн энгийн хөдөлгөөнүүдийн бичлэг - Бүжгийн хөгжмийн зохиолууд - Дасгалууд Техник хэрэгсэл: CD, DVD – бичлэг Дуут бүжиг, зохиомжит бүжгийн аязууд -Бүжгийн элементүүдийн зураглал, дасгал - Зохиомжит бүжгийн ноот, үг, бичлэг, бүжгийн хөдөлгөөнүүд Үлгэр, байгалийн сэдэвт бүжгүүд

	Багшийн анхаарах зүйл: Хөгжмийн зохиолоор дамжуулан утга санаа, дүрийг хөдөлгөөнөөр илэрхийлэхдээ, бүжгийн элемент, дасгалыг зөв хийдэг байх, хөгжмийн зохиолыг сонсоод дүр бүтээж чаддаг, бүтээсэн дүрдээ нэр өгөн улам боловсронгуй болгож чаддаг болоход чиглүүлж ажиллана.	
5.2г. Хөгжмийн энгийн зэмсгүүдийг ашиглан цохивор хөгжмийн найруулгыг жишээгээр харуулах	- Ангид байх хөгжмийн зэмсгээр (бишгүүр, үлээвэр даралтат хөгжим, цохивор хөгжмийн зэмсгүүд) хөгжимдөх арга барилд суралцана. - Сонсож буй хөгжмийн зохиолд хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөнө. - Зохиолын хэмнэл, хурд хүч, аялгууны шинж төрх, утга санааг илэрхийлж хөгжимдөнө. - Багшийн дохилтыг ойлгож хөгжимдөх, бусдыг сонсож ансамбльтай хөгжимдөнө. - Хурд, хүчний өөрчлөлтийг зэрэг илэрхийлж хөгжимдөнө. - Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг сонсож ойлгон дүр бүтээнэ. - Хөгжмийн энгийн зэмсэг бүтээх, өөрсдийн бүтээсэн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөнө. Жишээ нь: хушга ясыг ашиглан зэмсэг бүтээх... г.м Багшийн анхаарах зүйл: Хичээлд ашиглах хөгжмийн энгийн зэмсэг ховор байдаг тул багш та сурагчидтайгаа хамтран янз бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг хийж, бүтээлчээр хандаарай. Жишээ нь: Хушганы яс ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж болно. Мөн шагайг нүхлээд нилээд хэдийг утсанд хэлхээд тун өвөрмөц дуу чимээг гаргаж болдог, аюулгүй байдлыг нь хангаж чадвал хадаасыг ч ашиглан энгийн зэмсэг бүтээж болно.	Хөгжмийн зэмсэг: - Бишгүүр хөгжим - Даралтат хөгжим - Ангид байх хөгжмийн энгийн зэмсгүүд - Өөрсдийн хийсэн хөгжмийн зэмсгүүд
3. Хэлбэр		
5.3а. Эгшиг зохирлыг (консонанс, диссонанс, интервал) сонсож таних	- 1-3 тэмдэгтэй мажор, минорын хөгт ноот бичлэгийг ажиглана. - Хувиргалын тэмдгүүдийг уншиж, бичиж, тэмдэглэнэ. (диез, бемоль) - Аялгууны чиглэл хөдөлгөөнийг жишээн дээр тулгуурлан тодруулна. Жишээ нь: Нэг өнгө давтсан “Маамуу нааш ир”, Давалгаа маягийн хөдөлгөөн “Би цэцэг тарьсан”, Үсрэлттэй хөдөлгөөн “Ботго” Өгссөн, уруудсан – “Анхны хичээл” - Ноот бичлэгийг ажиглан сонсголын цээж бичиг хийнэ. - Аялгууг хэвээр хадгалан айзам хэмжээ өөрчлөгдөхийг ажиглаж сонсоно. (А, А₁, А₂) - Ардын болон хүүхдийн дууны ноот бичлэгт анализ хийн аялгууны давталт, ялгарамжийг олж тогтоон тайлбарлаж, харилцан ярилцана. - Аялгууны давталт, ялгарамжийг график дүрслэлээр дамжуулан илэрхийлнэ. - Дууны ноот бичлэгт ажиглалт хийж аялгууны давталт, ялгарамжийг график зураглалын дагуу сонсож тодорхойлно.	Сонсох хөгжим: - П.И.Чайковский “Цөмөөхэй” хятад бүжиг https://www.youtube.com/watch?v=eW1sR-A6AA8 - И.С.Бах Оркестрт зориулсан сюита №2 (си минор) Badinerie - К.Сен-Санс “Амьтдын багт наадам” – Заан Ном, сурах бичиг: - Хөгжим I сурах бичиг Техник хэрэгсэл: - CD DVD

5.3б. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулж, хөгжимдөх	- Өгөгдсөн ноот бичлэгийг ажиглаад, хоёр дэвсгэр шугамд бичсэн хэмнэлүүд хоорондоо ялгаатай эсэхийг ярилцана. - Канон, имитаци хэлбэрээр хөгжимдөнө. - Хэмнэлийн зураглалыг ноотоор, хурд хүчний нийлэмжээр дүрслэл илэрхийлж хөгжимдөнө. - Зураглалын дагуу сонсож, хурууны өндгөөр зөөлөн тогшиж хөгжимдөнө. Жишээ нь: хөгжилтэй аялал, намар, марш... г.м - Хөгжмийн зохиолд канон болон имитаци хэлбэрээр хамсраа хийнэ. - Сурсан дууны дахилтыг даган хөгжимдөнө. - Жижиг хэлбэрийн канон, имитаци хэлбэрийн аялгууг бишгүүр, даралтат хөгжмөөр хөгжимдөнө. - Хэмнэлээр канон хэлбэрт хөгжимдөнө. - Сонсголын тогтоолт дээр тулгуурлан хэмнэлээр хөгжимдөнө. - Хоёр хоолойн жижиг хэлбэрийн зохиолын хэсгээс хөгжимдөнө. Багшийн анхаарах зүйл: Канон, имитаци, секвенцтэй дасгал дуулах, хоёр хоолойн жижиг дасгал, амьсгааны дасгал, ноотоор дуулах дасгалыг уншуулах нь анхаарлаа төвлөрүүлэх, бусдыгаа сонсох, өөрийгөө сонсох чадварт хөтлөх ач холбогдолтой юм. Дууны уран бүтээлийг сонгоход бадаг эсвэл дахилт нь хоёр хоолойгоор бичигдсэн, жижиг хэмжээний хоёр хоолойн дуу байх нь зохимжтой.	Дуулах дуу: - С.Гончигсумлаа “Шинэ жил” - Т.Мөнхбаатар “Бидний шинэ жил” - When Christmas comes to town Техник, бусад хэрэглэгдэхүүн: -Dur, moll цомнолд тохирсон ардын болон хүүхдийн дууны бичлэг - Төгөлдөр хуур - Даралтат хөгжим - Бишгүүр - Металлафон - Ксилафон - Ардын хөгжим - Хөгжмийн энгийн зэмсгүүд...гм - Ноот, зогсоцууд орсон дасгалууд - Бөмбөр, дуут мод....
5.3в. Хөгжмийн зохиолын агуулга дүрийг хөдөлгөөнөөр илэрхийлэх	- Тодохой сэдвээр бүжиглэнэ. Жишээ нь: цас, хавар, эрвээхий г.м хөгжмийн аянд гар, хөл, биеийн хөдөлгөөнөөр утга санааг дүрслэнэ. - Гоцлол болон хамтлагаар бүжиглэх, хамтын хөдөлмөрийн үнэ цэнэ, үүргээ ухамсарлана. - Тойрон бүжгийн агуулга, дүр дүрслэлийг хөдөлгөөнөөр, тодорхой сэдэвт тохирсон хэрэгсэл ашиглан хийнэ. - Зохиомжит бүжгийн зохиолоос байгаль, амьтдын дүрийг тодорхойлон хөдөлгөөнөөр илэрхийлж тоглоно. - Тодорхой сэдвийн дагуу хөгжимт хөдөлгөөн бүжиг хийнэ. (шувуухай....) Багшийн анхаарах зүйл: Утга санаа дүр, дүрслэлийг илэрхийлэн бүжиглэхэд хэрэгсэлтэй болон хэрэгсэлгүй гүйцэтгүүлж болно. Бүжгийн дасгалын элементүүдийг хийхдээ хэрэгслүүдийг зөв барих, уран илэрхийлэлтэй гүйцэтгэх, өгөгдсөн сэдэв, зааврын дагуу бүжгийг хийж сурахад багш туслан чиглүүлэх үүрэгтэй. Мөн хөдөлгөөнөө хөгжмийн хэмнэл, аялгууны шинж төрхөд тохируулахыг анхааруулж байхыг зөвлөж байна. Бүжгийн утга санаанд сэтгэл хөдлөл, нүүрний хувирлыг зөв хослуулж гоцлол, цөөхүүл хэлбэрээр илэрхийлж сурахад анхаарлаа хандуулах нь зүйтэй.	Бүжиг: - “Ёохор” (тойрон бүжиг) https://www.youtube.com/watch?v=hg5nO7xQ6TQ - “Полька” (тойрон бүжиг) https://www.youtube.com/watch?v=MsfhvflvueY

5.3г. Өгөгдсөн аялгууг хөгжүүлэх, хувилбарлах	- “Руслан Людмила 2” дуурийн удиртгалыг сонсоод баатарлаг, сүр жавхлантай хурдан, уянгын тэмүүлэлтэй дуулалт шинж төрх, хурдан – удаавтар болохыг тодорхойлно. - Хэнтийн өндөр ууланд зохиолыг сонсоод удаан - хурдан - удаан А – Б – А хэлбэрийг тодорхойлно. - Хөгжмийн зэмсгийн дуугаралт, аялгууны хүчдэл, хурд, аялгууны шинж төрх, дүрслэл, утга санааг хөг эгшиглэгээтэй холбон тайлбарлаж тодорхойлно. - Зохиолын хэсгийг сонсож, гол аялгууг ноотоор уншина. - Хөгжмийн эгшиг, эгшгийн эрэмбэ, өрөг, мажор, минорын тэмдэглэгээ, хувиргалын тэмдгүүдийг ажиглан хөг эгшиглэгээг тодорхойлно. - Хөгжмийн зохиолыг сонсож анализ хийн агуулга хэлбэрийн нэгдлийг зурган дүрслэл ашиглан хялбар, энгийнээр ойлгоно. - Өгөгдсөн аялгууг хөгжүүлж хувилбарлана. Жишээ нь: И.Штраус полька “Трик трак” (Хөгжилтэй) Багшийн анхаарах зүйл: Өгөгдсөн аялгууг хөгжүүлж, хувилбарлан ангид байх хөгжмийн зэмсгүүд, бүжгийн хэрэгслүүд, дуунд хамсраа хийх гэх мэтээр хэрэглээ болгож чадвал ангийн хэмжээний концертыг сургууль, эцэг эхдээ үзүүлэх чадвартай болж байна гэсэн үг юм. Энэ нь зөвхөн хичээлээр үзсэн сэдвүүдийн дагуу байх хэрэгтэйг анхаараарай.	Сонсох хөгжим: - Э.Григ “Солвейгийн дуу” (Гуниг, харуусал) https://www.youtube.com/watch?v=4E0BoQgSPk8 - Б.Шарав “Сэрсэн тал” (Цоглог, хөгжилтэй) https://www.youtube.com/watch?v=CBZgie_31mo А.Бородин “Игорь ван” дуурийн II үзэгдлийн полов бүсгүйчүүдийн найрал дуу (Мөрөөдсөн, гуньсан) - https://www.youtube.com/watch?v=pWIT_fmIo6s
4. Хөгжмийн хэл		
5.4а. Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг (дуулаач, дан хөгжим) сонсож тодорхойлох	- “Утга үгүй бол шүлэг- шүлэг биш, аялгуу үгүй бол хөгжим-хөгжим биш” гэдэг үгийг өөрийнхөөрөө тайлбарлаж ярилцана. - Ноот бичлэгийг ажиглан сонсголын цээж бичиг хийнэ. - Дуулаач, дан хөгжмийн бүтээлийг сонсоод эгшиглэгээний онцлогийг мэдэрч мажор, минорын цомнолыг тодорхойлно. - Чиглүүлэх асуултаар төгөлдөр хуур хөгжмийн даруулуудын бүтцийг ажиглуулж, эгшиг хоорондын зай болон альтрацын (хувиргалын) тэмдгээр үүсмэл өргийг тодорхойлно. Жишээ нь: ✓ Төгөлдөр хуур хөгжмийн даруулуудын зургийг ажиглана. ✓ Хар даруулууд ямар дарааллаар зохион байгуулагдсан байна вэ? /хоёр хар, гурван хар гэсэн дараалалтай/ ✓ Ямар ямар эгшгүүдийн хооронд хар даралт байхгүй байна вэ? (Н - С, Е - F) ✓ Чагт хэлбэрийн # тэмдгээр эгшгийг аль чиглэлд хувиргах вэ? (дээшлүүлнэ) ✓ Зөөлний тэмдэгтэй адил Ь тэмдэгтээр эгшгийг аль чиглэлд хувиргах вэ? (доошлуулна) гэх мэт - Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг (дуулаач, дан хөгжим) сонсоод, хөгжмийн зэмсгийн дуугаралтыг ялгана.	Сонсох хөгжим: -Ц.Нацагдорж “Тэмээчдийн уралдаан” https://www.youtube.com/watch?v=U0p5--AEv0U - А.Вивальди “Жилийн дөрвөн улирал” (Хавар) -З.Батсүх “Таван эрдэнэ” https://www.youtube.com/watch?v=2jICpKevRIQ - Б.Шарав “Сэрсэн тал”

	Багшийн анхаарах зүйл: <i>Нэг хөгжмийн зохиолчийн ижил төрлөөр бичсэн хоёр зохиолыг (эсвэл 2 өөр хөгжмийн зохиолчийн бүтээл байж болно) сонсгоод тэдгээрийг хооронд нь харьцуулан жишиж ижил ба ялгаатай талуудыг олуулахад сурагчдын анхаарлыг чиглүүлнэ. Хөгжим сонсох сонирхолыг өдөөхөд анхаарлын төвлөрөлт хамгийн чухал байдаг. Жишээ нь: “И.С.Бахын ре минор, фа мажорын инвенцийг сонсоод дараах асуултын дагуу харьцуулж дүрсэн дээр хураангуйлж тэмдэглэ” гэсэн даалгаврыг багш сурагчдад өгч болно.</i> 1. Ямар хөгжмийн зэмсэгт бичсэн зохиол вэ? 2. Зохиол тус бүрийн цомнолыг тодорхойл. 3. Ямар хэмжээнд (размер) бичигдсэн байна вэ? 4. Аялгууны шинж төрх ямар байна вэ? 5. Сонссон зохиолын хурдацыг тодорхойлно уу? 6. Зохиолын хүчдэлийн талаар ярилцана уу? 7. Зохиол хэдэн хэсгээс бүтсэн бэ? г.м	
5.46. Удирдаачийн дохиогоор хурд хүчний өөрчлөлтийг илэрхийлж гоцлол, найрал хэлбэрээр дуулах, хөгжимдөх	- Удирдаачийн дохиогоор хурд, хүчний өөрчлөлтийг анхаарч, үгийг зөв, гүйцэд, тод хэлж дуулна. - “Туйлын галт тэрэг” хүүхэлдэйн киноны дуунд анализ хийх, үг хэллэг, өргөлт акцентийг зөв илэрхийлж дуулна. ✓ Итгэл үнэмшил хүнд яагаад хэрэгтэйг гол дүрүүдээс жишээ авч ярилцана. “Туйлын галт тэрэг” ✓ Ноотоор дуулна. ✓ Үгийг орчуулах, зөв хэллэг, үгийн хуваарилалтийг анхаарна. - Christmas alphabet - Шинэ жил гэсэн үгний үсэг бүрийг үг болгон хэрхэн тайлбарлаж дуу болгосныг ярилцана. ✓ амьсгааг зөв хуваарилана. ✓ гоцлол, цөөхүүл, найрлаар дуулна. - Ноотоор дэвсгэр шугам дээр тэмдэглэх, унших, багцлах, бодох, дуулах дадлага хийнэ. - Дууны аялгууны хурдыг мэдэрч, тэмдэглэгээг уншиж дуулах дадлага хийнэ. - Ноотны хэмжээг багцлан ойлгон тэмдэглэж, уншиж, дуулна. - 2 болон 3, 4 хувьт хэмд ноотыг тэмдэглэх, унших, багцлах, хэмнэлийн дасгал гүйцэтгэнэ. - Ноотны зогсоцыг ойлгож, тэмдэглэгээг уншиж зөв дуулна. - Дууны утга санаа дүрслэлийг дэвтэртээ зурж илэрхийлнэ. - Дуулах дууны хөг, тусгайлан тэмдэглэсэн хэсгийн эгшиг хоорондын зайг тодорхойлно. - Эгшгийн өндөр намыг график зураглалтай холбон сонсож дуулна. Багшийн анхаарах зүйл: Сурагчдыг ноотоор дуулах чадварт сургахдаа чухам юу дуулах гэж байгаагаа, дуулах аялгууны хөдөлгөөн хаашаа чиглэж буйг, ямар зайд (интервал) хаашаа хөдлөхийг ойлгуулах нь зүйтэй юм.	Дуулах дуу: - Г.Эрдэнэчулуун “Дуулж аргадах нутаг” - Х.Ягаанцэцэг “Зээрд халзан” - Г.Пүрэвдорж “Түүдэг гал” - Б.Ганхуяг “Дуу шиг хавар” - С.Ганчимэг “Хүүхэд нас” - Б.Цогоо “Туждаа хамт явах юм сан” Үзүүлэн, ТӨМ: CD, DVD бичлэг Зурагт үзүүлэн

	Мөн гоцлол, найрал хэлбэрээр дуулахдаа удирдаачийн дохиогоор хурд хүчний өөрчлөлтийг илэрхийлж дуулахад анхаарах. Хөгжим сонсох үйл ажиллагаанд симфони найрал хөгжмийн зэмсгүүдийн том, өнгөт үзүүлэнг бэлтгэн хөгжим сонсгох явцдаа тухайн зохиолд хөгжмийн зэмсгүүдийн үүрэг, дуугаралтыг тодорхойлж, самбар дээр байрлуулах байдлаар ажиллаж болно.	
5.4в. Хөгжим болон хөдөлгөөний уялдаа холбоог тайлбарлах	- Бүжгийн хөдөлгөөнийг зөв цэвэр хийж гүйцэтгэнэ. - Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг ашиглан хөгжим зохионо. - Өгөгдсөн дасгалын айзам хэмжээг тодорхойлж багцлана. - Хялбар хэмнэлтэй, энгийн бүтэцтэй аялгууг бие даан болон хосоороо зохиож найруулах, ярилцах, хөгжимдөж, дуулж үзүүлнэ. - Өгөгдсөн сэдвийн дагуу бүтэн, хагас, дөрөвт, наймт ноот, тэдгээрийн зогсоцуудыг ашиглан 2-4 такт зохиол бичиж, хөгжимдөнө. Жишээ нь: цасан хүн-нар, галт тэрэг гэх мэт - Бие даан янз бүрийн хэмнэлийн багцлалуудыг зохиож, найруулна. Жишээ нь: цохиур хөгжимд зориулан өөрийн дуртай дуу, хөгжмийн зохиолд тулгуурлан хэмнэл зохиох, баяжуулах, найруулан тоглох, бусадтай хамсран тоглох гэх мэт - Бүжгийн энгийн элемент бүхий дасгалыг ашиглан цэнгээнт, орчин үеийн бүжгийг зохиомжлоно. - Хөгжмийн дүр дүрслэлийг хөдөлгөөнөөр хэрхэн илэрхийлж болохыг дүрслэн харуулж, зохиомжлоно. Багшийн анхаарах зүйл: Сурагчид хичээл дээр сонссон хөгжмөө ойлгож, аажмаар хэрэглээ болгон авьяасаа бүтээлчээр хөгжүүлэхэд түлхэц болох оновчтой аргуудыг олж сэдэхэд багшийн зүгээс санаачлага хэрэгтэй. Хичээлийн жилийн турш сонссон зохиолоо таньж буй эсэхийг шалгахдаа хөгжмийн тааврыг (викторина) сонирхолтой хэлбэрээр зохиох, баг болон анги хамт олны дунд эсвэл 2 бүлгийн дунд АХА маягийн тэмцээн зохиох, хөгжмийн нэр томъёог тогтоолгох зорилгоор “Бинго” тоглоомын аргыг ашиглах зэргээр сурагчдын идэвхийг өрнүүлэх олон хувилбарыг сонгож үйл ажиллагаандаа хэрэгжүүлээрэй.	Хөгжимт хөдөлгөөн: - “Ангийн бүжиг” (Л.Галмандах “Дэгдээхэй нас”дуу) - “Вальс” https://www.youtube.com/watch?v=SQGw6ax3Jyw - “Бүжиглэгцгээе” Л.Галмандах “Бага насаа хайрлаж явъя”

5.4г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг янз бүрийн арга хэлбэрээр (өнгө будаг, зураглал) илэрхийлэх	- Хөгжмийн дүр дүрслэлийг хөдөлгөөнөөр хэрхэн илэрхийлж болохыг дүрслэн харуулж, зохиомжлоно. - Ноотны дэвтэрт өөрийн зохиомж, найруулгаа балын харандаагаар (засах, өөрчлөх болоомжтой) бичих, загвар ашиглана. - Өгөгдсөн эгшгээс, өгөгдсөн интервалыг байгуулах замаар зааврын дагуу найруулга хийнэ. - Сэдэвт тохирсон таавар, тоглоом зохиох, бусаддаа зориулж энэ сэдвийн талаар тайлбар бичнэ. - Лааз ашиглан бөмбөр хийх, зохиолыг 2-4 тактаар үргэлжлүүлнэ. - Хялбар хэмнэлтэй, энгийн бүтэцтэй аялгууг бие даан болон хосоороо зохион найруулаад хөгжимдөж, дуулж үзүүлнэ. - Өгөгдсөн зураглалын дагуу сонирхолтой аялгуу зохионо. - Аялгууны айзам хэмжээг өөрчлөн найруулах хувилбар зохионо. - Тоглолтын хөтөлбөр боловсруулна. ✓ “Сонирхолтой бодлого” ✓ “Хөгжилтэй ноот” мэдлэг ур чадвараа сорих уралдаан тэмцээний хөтөлбөр, удирдамж боловсруулах, удирдамжийн дагуу уралдаан зохион байгуулна.	Сонсох хөгжим: - К.Сен-Санс “Хөхөө” https://www.youtube.com/watch?v=L0y7UUxf8Mw - А.Хачатурян “Сэлэмт бүжиг” https://www.youtube.com/watch?v=aH2Gpdr-WrA&list=RDaH2Gpdr-WrA&start_radio=1 - Н.А.Римский-Корсаков “Хэдгэнийн нисэлт” https://www.youtube.com/watch?v=myTrXG64C0c Үзүүлэн, ТӨМ: Ноотны дэвтэр, харандаа, баллуур Тэмдэг, тэмдэглэгээ бүхий үзүүлэн Техник хэрэгсэл: CD, DVD - бичлэг
---	---	---

ХАВСРАЛТ

Нэг. Дууны урын сан:

Дөрвөн улирал сэдвээр:

1-р анги

- Хөг. С.Задгай шүл. С.Батболд “Цасаа цасаа ороорой”
- Хөг. Д.Жанчив шүл. Д.Өлзийням “Бороо”
- Хөг. Ц.Сүхбаатар шүл. Д.Содномдорж “Зун цаг”
- “Бороо” (rain)
- Хөг. Б.Цэвээнсүрэн шүл. О.Сундуй “Яргуй дэлгэрлээ”

2-р анги

1. Хөг.Ц.Сүхбаатар шүл. Д.Содномдорж “Шувуухайн байшин”

3-р анги

- Хөг.З.Хангал шүл. Д.Батсүрэн “Нарны бүжиг”

4-р анги

- Хөг. С.Батболд шүл. О.Сундуй “Аяны шувууд ирлээ”
- Хөг. Х.Сэргэлэн шүл. Я.Балжид “Хөх яргуй”
- Хөг. Г.Пүрэвдорж шүл. Ж.Дашдондог “Шинэ өглөө”

5-р анги

- Хөг. С.Ганчимэг шүл. Б.Мягмарсүрэн “Хавар ээж”

Амьтад сэдвээр:

1-р анги

- МАД 12 жил
- “Унага”
- Хөг. С.Баярсайхан шүл. Ч.Алагсай “Ботго”
- Хөг. Х.Баатар шүл. Б.Доржсүрэн “Дуучин ботго”
- Хөг. Т.Чимиддорж шүл. М.Чойжил “Эрх цагаан ишиг”
- Хөг. Д.Жанчив шүл. Д.Өлзийням “Унага”
- Хөг. С.Батболд шүл. Г.Ганболд “Муур хулганы дуу”
- Хөг. С.Ганчимэг “Тахиа”
- Хөг. Х.Баатар шүл. Ш.Цэен-Ойдов “Бор шувуу”
- Хөг. Л.Галмандах шүл. З.Нямцэрэн “Үнэгний гавар”
- Хөг. Л.Галмандах шүл. З.Нямцэрэн “Баавгайн бамбарууш”
- Хөг. Л.Галмандах шүл. З.Нямцэрэн “Зээрийн янзага”
- Хөг. Л.Галмандах шүл. З.Нямцэрэн “Цааны хугаш”
- Хөг. Ч.Алтансүх шүл. Ц.Нүүдэл “Хулгана”
- “Шаазгай”

2-р анги

- Хөг. Г.Пүрэвдорж. шүл. Ж.дашдондог “Байгаль эхийн хүүхдүүд”
- Хөг. С.Ганчимэг “Баавгай”
- Хөг. Б.Түмэнжаргал шүл. З.Түмэнжаргал “Бөмбөг битгий хаяаарай”
- Торгууд ардын дуу “Агсал”
- Хөг. Ч.Алтансүх шүл. Ц.Нүүдэл “Соён хээр”
- Хөг. С.Батболд шүл. Б.Банди “Ботго”

- Хөг. С.Батболд шүл. Б.Банди “Хурга”
- Хөг. С.Батболд шүл. Б.Банди “Ишиг”
- Хөг. С.Батболд шүл. Б.Банди “Тугал”
- Хөг. С.Батболд шүл. Б.Банди “Унага”
- Хөг. Ч.Нянгар шүл. Д.Дэндэв “Цагаан ишиг”
- Хөг. С.Ганчимэг “Хэрэм”
- Хөг. С.Ганчимэг “Туулай”

3-р анги

- Хөг. Ц.Нацагдорж шүл. Б.Чимиддорж “Балчир насны нөхөр”
- Хөг. Л.Галмандах шүл. Ш.Бадарч “Ижийдээ л хөөрхөн”
- Хөг. С.Баярсайхан шүл. Д.Нямаа “Шагшраа хөөрхөн болжмор”
- Хөг. Ж.Дашдондог шүл. Д.Дэнсмаа “Миний бяцхан найзууд”

4-р анги

- Хөг. Г.Эрдэнэбаатар шүл. Д.Нацагдорж “Хэнз хурга”

Шинэ жил сэдвээр:

1-р анги:

- Хөг. Г.Дарамзагд шүл. Ц.Балгансүрэн “Сүлд модны наадмын тойрон бүжгийн дуу”

2-р анги

- Муз. Л.Бекман сл. Кудашевой “Ёлочка” (В лесу родилась)
- Хөг. С.Батболд шүл. Л.Соронзонболд “Цасхан”
- Новый год
- Шинэ жилийн тойрон бүжиг
- Happy new year

3-р анги

- Хөг. шүл. Н.Шонхор “Шинэ жил”
- Снег-снежок

4-р анги

- Хөг. Шүл.С.Батболд “Шинэ он”
- Хөг. Г.Энхбаяр “Зулзгаган ногоон гацуурхан”
- Merry Christmas

5-р анги

- Хөг.С.Гончигсумлаа “Шинэ жил”
- Хөг.Т.Мөнхбаатар шүл. Б.Ганзориг “Бидний шинэ жил”

Гэр бүл сэдвээр:

1-р анги:

- Хөг. Ч.Сангидорж шүл. М.Чимид “Ээжийн баяр”
- Хөг. Ц.Сүхбаатар шүл. Д.Содном “Би цэцэг тарьсан”
- Хөг. Ж.Шараа шүл. Д.Лхашид “Миний хөөрхөн дүү”
- Баяд ардын дуу “Эхийн дуу”
- Хөг. Д.Пунцагдорж шүл. Ч.Батсүрэн “Хамгийн сайхан ээж” Хүүхдийн дуу

2-р анги

- Хөг. З.Хангал шүл. С.Дашдооров “Цэцэг юмуу би”

- Хөг. Д.Балжинням шүл. Г.Ганболд “Айраг бүлэх”
- Хөг. Л.Алтангэрэл шүл. Я.Отгонжаргал “Лууван”

3-р анги

- Хөг. Бямбабаяр шүл. Д.Чинзориг “Болохгүй, болохгүй”
- Хөг. Л.Галмандах шүл. Т.Галсан “Аав ээждээ”
- Хөг. С.Ганчимэг “Дүү минь нойрс доо”
- Хөг. Б.Бат-Эрдэнэ “Дэгдээхэй нас”
- Хөг. Т.Мөнхбаатар шүл. Г.Өнөбат “Үр нь хайртай”

4-р анги

- Хөг. Ц.Сүхбаатар шүл. Д.Содномдорж “Аз жаргалын эрэлчин” дуурийн Хумбага Боролдойн дуу
- Хөг. Ш.Баттогоо шүл. Г.Ганболд “Би унтлаа”

5-р анги

- “Ээждээ би хайртай”

Эх орон сэдвээр:

1-р анги:

- Хөг. Л.Галмандах шүл. Ч.Пүрэвчулуун “Зүүдний Чингис”

2-р анги

- Хөг. С.Ганчимэг шүл. Д.Саранхүү “Монгол нутгийн үрс”

3-р анги

- Хөг. С.Ганчимэг шүл. Б.Нацагдорж “Дууны түрлэгтэй хүүхэд нас”

4-р анги

- Хөг. Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж “Монгол Улсын төрийн дуулал”
- Хөг. Ц.Намсрайжав шүл. Ж.Бадраа “Халуун элгэн нутаг”
- Хөг. Б.Шарав шүл. Д.Нацагдорж “Хорвоо амгалан байг” (Байлдааны даалгавар киноны дуу)
- Хөг. С.Ганчимэг шүл. Т.Алтанцэцэг “Миний эх орон”
- Хөг. Т.Мөнхбаатар шүл. З.Түвшинзаяа “Эх орон байгаль дэлхий”

5-р анги

- Хөг. С.Батболд, Ө.Баасанжав “Өглөө”

Сургууль найз нөхөд сэдвээр:

1-р анги:

- Хөг. Л.Галмандах шүл. З.Нямсүрэн “Сургуульдаа би тэмээгээр явна”
- Хөг. С.Гончигсумлаа шүл. Ш.Шажинбат “9 сарын 1”
- Хөг. С.Батболд, шүл. Ж.Дашдондог “Харандаа баллуур”
- Хөг. С.Батболд, шүл. О.Сундуй “Би дуучин”
- Хөг. Ч.Алтансүх шүл. Ц.Нүүдэл “Алтан намар”
- Хөг. Ц.Чинзориг шүл. Д.Пүрэвсүрэн “Эрдмийн туяа”
- Хөг. Д.Оюунтүлхүүр шүл. Энхээ “Анхны хичээл”
- Хөг. Л.Галмандах шүл. Ж.Дашдондог “Арав гэж юу вэ?”
- Хөг. С.Батболд шүл. Ж.Дашдондог “Бүх үсгийн найрал дуу”
- Хөг. С.Батболд шүл. Ж.Дашдондог “Эгшиг үсгийн дуу”

- Хөг. С.Батболд шүл. Ж.Дашдондог “Туслах эгшгийн дөрвөл”
- Хөг. С.Батболд шүл. Ж.Дашдондог “Онцгой дөрөв”
- Хөг. С.Батболд шүл. Ж.Дашдондог “Хатуу, зөөлний тэмдгийн хоршил”
- Хөг. С.Гончигсумлаа шүл. Н.Санжмятав “Тэгвэл хоёулаа”
- Хөг. Баттөмөр шүл. Д.Дашдондог “Ногоон гэрэл”
- Хөг. С.Батболд шүл. Д.Содномдорж “Олуулаа”
- Хөг. С.Батболд шүл. С.Бодоош, Л.Соронзонболд “Бага ангийн багшдаа баярлалаа”
- Хөг. Т.Булган шүл. Д.Отгонсүрэн “Эрдмийн үсгээ сурлаа”
- Хөг. Л.Галмандах шүл. З.Түмэнжаргал “Бөөн баяр”
- Хөг. С.Мааяа шүл. Ж.Дашдондог “Яагаад”
- Хөг. М.Ганболд шүл. Г.Хүрэлбаатар “Багшаа би би”
- Хөг. Л.Галмандах “Шүдээ хайрлъя”
- Хөг. С.Батболд шүл. Л.Соронзонболд “Би жагсаж чадна”

2-р анги

- Хөг. Ч.Алтансүх шүл. Ц.Нүүдэл “Есөн сарын нэгэн”
- Хөг. шүл. С.Батболд “Миний дотны найзууд”
- Хөг. С.Батболд.шүл. Д.Отгонтуяа “Нар-Сар-Од”
- Хөг. С.Батболд.шүл. О.Сундуй “Уярлын долоон эгшиг”
- Хөг. С.Батболд.шүл. О.Сундуй “Шинэ он айсуй”
- Хөг. С.Ганчимэг шүл. Д.Саранхүү “Та нар бидэнтэй хамт”
- Хөг. Ч.Нянгар шүл. Д.Цэдэв “Цагаан ишиг”
- Хөг. С.Батболд шүл. О.Сундуй “Сурагчийн дэвтэр”
- Хөг. С.Батболд шүл. Ш.Бадарч “Дээс дээс”
- “Янзаган нас”
- Хөг. Л.Галмандах шүл. С.Сүхбаатар “Дэлхий дүүрэн бага нас”

3-р анги

- Хөг. С.Ганчимэг шүл. Д.Саранхүү “Охид хөвгүүдийн тоглоом”
- Хөг. З.Хангал шүл. Д.Батсүрэн “Нарны бүжиг”
- Хөг. С.Мааяа шүл. Ш.Сүрэнжав “Сайн уу муу юу аль нь вэ хө”
- Хөг. Л.Даваахүү шүл. Х.Найдан “Нэг ангийнхан”
- Хөг. С.Батболд шүл. О.Сундуй “Хурдан морины хүүхэд”
- “Хэрвээ чи аз жаргалтай бол”
- Хөг. Г.Пүрэвдорж шүл. Ж.Дашдондог “Тавтай нойрсоорой”
- Хөг. С.Ганчимэг шүл. Алтанцэцэг“Цаг”

4-р анги

- Хөг. З.Хангал шүл. Д.Батсүрэн “Зургийн хичээл”
- Хөг. Р.Энхбазар шүл. Ц.Гайтав “Өглөөний тухай дуу”
- Хөг. С.Батболд. шүл. С.Соронзонболд “Дайн хэрэггүй”
- Хөг. С.Батболд. шүл. Б.Нацагдорж “Хэлье үү, байя уу”
- Хөг. С.Батболд. шүл. З.Түмэнжаргал “Анд нөхөд минь явяхад”
- Муз. А.Островского сл. Л.Ошанина “Пусть всегда будет солнце”
- Хөг. Т.Чимиддорж шүл. Ж.Дашдондог “Сайн байна уу?”
- Хөг. Л.Даваахүү шүл. Х.Найдан “Нэг ангийнхан”
- Хөг. Л.Галмандах шүл. Д.Мандахсан “Үерхэл чамайгаа нандигнана”
- Хөг, шүл. Р.Энхбазар “Угтагчийн дуу”
- Хөг. Г.Жаргалсайхан шүл. Ш.Гүрбазар “Хүүхэд шувуу хоёр”
- Муз. В.Шайнского “Антошка”

5-р анги

- Хөг. Т.Чимиддорж шүл. Ө.Баасанжав “Мөрөөдөл”

- Хөг. Т.Чимиддорж шүл. Ө.Баасанжав “Нараа баясан угтъя”
- Хөг. Л.Галмандах шүл. З.Түмэнжаргал “Бага насаа хайрлаж явъя”
- Хөг. И.Болоож шүл. Д.Пүрэвдорж “Нар инээдэг юм”
- Хөг. Л.Балхжав шүл. Ү.Хүрэлбаатар “Нарны хаан хүүхэд”
- Хөг. С.Батболд.шүл. Ж.Дашдондог “Миний дотны найзууд”
- Хөг. С.Батболд.шүл. Ш.Бадарч “Гэрэлт нарны хүүхдүүд”
- Хөг. С.Батболд.шүл. Д.Хүү “Мөнх тэнгэрийн орон”
- Хөг. С.Алтануяа шүл. Д.Тэнгэрханд “Дэлхийн найзууддаа”
- Хөг. Г.Эрдэнэбаатар шүл. Д.Нацагдорж “Миний хэнз хурга”
- Хөг. С.Ганчимэг “Хүүхэд нас”
- Happy birthday
- Twinkle twinkle little star

Хөгжимт хөдөлгөөн, дуут бүжиг, хөгжимт тоглоом

1-р анги:

- “Чулуу хайч цаас”
- “Дуулъя бүжиглье”
- “Навчис”
- “Далай”
- Үг. З.Болдбаатар Ая. Ч.Алтансүх “Цэвэр гар”
- “Ангаахай”
- “Алга ташиж тоглоцгооё”
- “Цасан хүн”
- “Хүүхэлдэй”
- “Бөмбөрчин”
- Үг. Д.Амарсанаа Ая. Б.Өнөржаргал “Шүдээ угаацгаая”
- Үг. О.Сундуй Ая. Б.Цэвээнсүрэн “Яргуй дэлгэрлээ”
- “Хавар”

2-р анги

- “Шувуухай”
- “Бөжин”
- Үг. А.Найгалмаа Ая. Б.Өнөржаргал “Мэлхий”
- “Дарцагтай дасгал”
- “Завь”
- “Ишиг”
- “Хургачин”
- “Эрвээхэй”
- Үг. Ц.Нүүдэл Ая. Ч.Алтансүх “Хулгана”

3-р анги

- “Шувуухай”
- Үг. Д.Амгалан Ая. Б.Цэвээнсүрэн “Зохицуулагч”
- “Тахиа”
- “Бий биелгээ”
- “Оцон шувууд”
- “Марш”
- “Цэцэгс”
- Үг. Ш.Энхбаяр Ая. А.Балжинням “Тогоруухай”
- “Дэвүүрт”
- МАД “Торойн цагаан элс”

4-р анги:

- “Ёохор”
- Үг. Ц.Нүүдэл Ая. Ч.Алтансүх “9 сарын 1”
- “Заан”
- “Дөрвөд биелгээ”
- “Хамтдаа бүжиглээ” (Тойрон бүжиг)
- “Уралдаан”
- Тогорууны бүжиг”
- “Таягт”
- “Хосоороо бүжиглээ”
- “Хүндэтгэлийн бүжиг”

5-р анги:

- Хөг. С.Гончигсумлаа “Буриад бүжиг”
- “Навчис”
- “Хун” (гарын дасгал)
- “Алчууртай бүжиг”
- “Ботго”
- “Ангийн бүжиг”
- “Вальс”
- “Бүжиглэцгээ”
- “Ёохор”
- “Полька” (тойрон бүжиг)

Хоёр. Сонсох хөгжмийн урын сан:

1. Ч.Сангидорж “Хүүхдэд зориулсан симфони аязууд”
2. Ч.Сангидорж “Хэрэм”, “Баавгай”
3. С.Баатарсүх “Хөгжилтэй зугаалга”
4. Б.Наранбаатар “Ятгад зориулсан хүүхдийн аяз”
5. С.Гончигсумлаа “Төгөлдөр хуурт зориулсан аязууд”
6. С.Гончигсумлаа “Морь”
7. С.Гончигсумлаа “Бодол”
8. С.Гончигсумлаа “Марш”
9. С.Гончигсумлаа “Буриад” бүжиг
10. С.Гончигсумлаа “Вальс”
11. Ц.Нацагдорж “Хөдөөгийн сайхан чуулбар”
12. Ж.Чулуун “Уран хас”
13. Н.Цэрэнпил “Миний нутаг”
14. Ц.Намсрайжав “Баярын жавхаа”
15. Ц.Намсрайжав “Говь гурван сайхан”
16. Ц.Намсрайжав “Хувьсгалт баатарлаг марш”
17. Идэрбат “Төвөргөөн”
18. Ж.Чулуун “Уулын горхи”
19. Ж.Чулуун “Уран хас” адажио
20. Ж.Чулуун “Монгол ардын хоёр дууны хувилбар аяз”
21. Л.Мөрдорж “Цэнгэлийн эгшиг”
22. Л.Мөрдорж “Ганзам”
23. Л.Мөрдорж “Түүхт хил”
24. Л.Мөрдорж “Унаган жороо”
25. Л.Мөрдорж “Эх орон”
26. Н.Жанцанноров “Монгол аялгуу”
27. Н.Жанцанноров “Уралдаан”
28. Н.Жанцанноров “Хөөс хөөс”

29. Т.Чимэддорж “Зуслангийн зүг”
30. Б.Дамдинсүрэн “Нэнтийн өндөр ууланд”
31. Г.Бирваа “Улаан дарцаг”
32. Г.Бирваа “Уянгын аяз”
33. Г.Цэрэндорж “Хөдөөгийн залуус”
34. Ж.Мэнд-Амар “Хөдөлмөрийн жавхаа”
35. Э.Чойдог “Жалам хар”
36. С.Бүтэд “Үелзүүр”
37. Б.Шарав “Сүхийн цагаан морь”
38. М.П.Мусоргский “Үзэсгэлэнийн зургууд”
39. М.П.Мусоргский “Цэцэрлэгт хүрээлэн”
40. М.П.Мусоргский “Хуучин цайз”
41. К.Сен-Санс “Амьтдын наадам”
42. К.Сен-Санс “Усан доторх амьдрал”
43. К.Сен-Санс “Хун”
44. К.Сен-Санс “Төгөлдөр хуурч”
45. П.И.Чайковский “Шелкунчик”
46. П.И.Чайковский “Цөмөөхэй” бүжгийн жүжгийн Чихрийн бүжиг
47. П.И.Чайковский “Хунт нуур” бүжгэн жүжгийн “Дэгдээхийн бүжиг”
48. П.И.Чайковский “Жилийн дөрвөн улирал”
49. П.И.Чайковский “Аравдугаар сар”
50. П.И.Чайковский “Завьчны дуу”
51. П.И.Чайковский “Цэцгийн вальс”
52. П.И.Чайковский “Модон цэргийн марш”
53. П.И.Чайковский “Хятад бүжиг”
54. Ж.Фужик “Марш”
55. В.А.Моцарт “Рондо”
56. Л.В.Бетховен “Баяр баяслын дуулал”
57. Л.В.Бетховен “Элизе”
58. И.Брамс “Бүүвэйн дуу”
59. Э.Григ “Өглөө”
60. И. Штраус “Орос марш”
61. Д.Кабалевский “Бүрээч, бөмбөрч”
62. Д.Кабалевский “Гурван охин”
63. Г.Левкодимова “Баавгай”, “Туулай”,
64. Г.Левкодимова “Уйтгартай”, “Тайван”, “Хөгжилтэй”
65. Г.Левкодимова “Вальс”
66. А.Лешгорн “Аялгуу”
67. И.С.Бах “Волынка”
68. М.И.Глинка “Вальс”
69. М.И.Глинка “Руслан Людмила хоёр”
70. М.И.Глинка “Черноморийн марш”
71. Н.А.Римский-Корсаков “Зөгийн нисэлт”
72. Н.А.Римский-Корсаков “Шехеразада”
73. А.Хачатурян “Сэлэмт бүжиг”
74. С.Прокофьев “Петя чоно хоёр”
75. Ф.Лист “Бодол”
76. Ф.Саппэ “Гэрэл гэгээ”
77. Д.Шостакович VII симфони
78. К.Дебюсси “Цасны бүжиг”
79. Р.Шуман “Хүйтний өвгөн”
80. Р.Шуман “Бяцхан цэргүүдийн марш”
81. Ф.Шуберт “Төгсөөгүй” симфони
82. Ж.Бизе “Кармен” дуурийн удиртгалын марш

